MONGOLIAN WOOL & CASHMERE ASSOCIATION

EXPORT DEVELOPMENT PROJECT

БНХАУ-ЫН НООС, НООЛУУРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Улаанбаатар хот
2018 оны 5 сар

Дэлхийн банкны Экспортыг дэмжих төслийн хүрээнд Монголын ноос, ноолуурын холбооны захиалгаар бэлтгэв.

ГАРЧИГ

ТОВЧ АГУУЛГА 5
1. БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ ШИНЖИЛГЭЭ 6
1.1 Хятадын ноос, ноолуурын салбарын өнөөгийн байдал 6
1.2 Хятадын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн судалгаа 9
1.3 Дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөөний хүчин зүйлс 15

2. ТҮГЭЭМЭЛ ҮЙЛДВЭРЛЭДЭГ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР-ҮНИЙН ХАМААРЛЫН СУДАЛГАА 17

3. ХЯТАДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ 19
3.1 Зах, зээлийн багтаамж, цаашдын төлөв 19
3.2 Хятадын зах зээлд нэвтрэх боломж-Импортын шинжилгээ 22

4. ХЯТАДЫН НООС, НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРТ АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ГАРАЛ ҮҮСЛИЙН СУДАЛГАА 25

5. ХЯТАД ХЭРЭГЛЭГЧДИЙН ОНЦЛОГ, БОРЛУУЛАЛТЫН СУВАГ 27
5.1 Хятад хэрэглэгчдийн орлого, хэрэглээний хандлага 27
5.2 Дундаж давхаргын хэрэглэгчдийн худалдан авалтын зан төлөв: 29
5.3 Хүн ам зүйн бүтцээс хамааралтай худалдан авалтын зан төлөв 31
5.4 Борлуулалтын суваг 32

6. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, СТАНДАРТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА 35

7. ЗАСГИЙН ГАЗРААС НООС, НООЛУУРЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ ХӨНГӨЛӨЛТ, ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА 40
7.1 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт үзүүлж буй дэмжлэг туслалцаа 40
7.2 Малын үүлдэр, ноос, ноолуурын түүхий эдийн чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хийгдсэн Засгийн газрын бодлого, дэмжлэг 49

8. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ 53

9. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ 56

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Хятадын ноолуурын гарц, бүс нутгаар 8
Хүснэгт 2: Хятадын ноолууран зах зээлийн хувь 9
Хүснэгт 3: Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн ангилал 17
Хүснэгт 4: Ноолууран бүтээгдэхүүний үнийн судалгаа 18
Хүснэгт 5: Амьтны гаралтай ноос, ноолууран бүтээгдэхүүний импорт 19
Хүснэгт 6: Монгол улсаас Хятад улсад нийлүүлсэн ноос, ноолууран бүтээгдэхүүн, Хятадын нийт импортод эзлэх хувь 23
Хүснэгт 7: Хятадын ноос, ноолуур боловсруулах тоног төхөөрөмжийн импортын судалгаа 25
Хүснэгт 8: Хятадын ноос, ноолуур боловсруулах тоног төхөөрөмжийн (нэхмэлийн) импортын судалгаа 26
Хүснэгт 9: Үндэсний стандартын ангилал 35
Хүснэгт 10: Сүлжмэл эдлэлийн салбарт дагаж мөрдөх стандартууд 37
Хүснэгт 11: GB18401 сүлжмэл бүтээгдэхүүний техникийн аюулгүй байдлын шаардлага 38
Хүснэгт 12: GB/T18267 стандартын шаардлага 39
Хүснэгт 13: Хятадын ноос, ноолуурын салбарт баримталж буй бодлого шийдвэрүүдийн жагсаалт 42
Хүснэгт 14: “Дэлхийд гарах” бодлогын хүрээнд олгосон татаас 43
Хүснэгт 15: Өвөр Монголын Ордос ресурс ХК-ийн 1999-2006 онд авсан санхүүгийн дэмжлэг 49
Хүснэгт 16: Хөдөө аж ахуйн нөөц, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад зориулсан татаас 51
Хүснэгт 17: Малчид тариачдын эдийн засгийн нөхөрлөл, хамтын ажиллагаанд зориулсан татаас 51
Хүснэгт 18: Хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухаан технологийн дэвшлийг нэвтрүүлэх сангаас олгосон татаас 52

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1: Хятадын ноолуурын гарц (тн) 6
График 2: Хятадын ноосны гарц (тн) 7
График 3: Хятадын ноос боловсруулагч үйлдвэрийн нийт эрэлт, тн 7
График 4: Хятадын интернет худалдаа 30

ТОВЧ АГУУЛГА

Хятадын эдийн засаг хурдацтай өсөхийн хэрээр Хятад хэрэглэгчдийн орлого өсөж, тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна.

Нийт 1,3 тэрбум гаруй хүн амтай тус улсын хувцасны зах зээлийн хэмжээ нь 1,144 тэрбум юаниар үнэлэгдэж, цаашид ч энэ үзүүлэлт өсөх хандлагатай байгаа тул экспортлогчдын хувьд өндөр ач холбогдолтой зах зээл юм.

Ноос, ноолуурын түүхий эдээр дэлхийд дээгүүрт ордог манай улсын хувьд тус зах зээлд нийлүүлж буй бүтээгдэхүүн нь Хятад улсын ноос, ноолууран хувцасны 4.4 тэрбум юанийн үнэ бүхий импортын 1%-д ч хүрэхгүй байгаа нь чамлалтай үзүүлэлт юм. Иймд тус зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбоотой хэрэглэгчдийн зан төлөв, борлуулалтын суваг, чанар стандартад тавигдах шаардлага болон өрсөлдөөний хүчин зүйлсийг сайтар судлан бүтээгдэхүүнээ гаргах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй. Хятад улсын ноос, ноолууран хувцасны зах зээлд Хятадын дотоодын компаниуд хүчтэй өрсөлдөгчид юм.

Хятад улсын ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1990-ээд оноос эрчимтэй хөгжин дэлхийн зах зээлд чухал байр суурь эзлэх болсон. Хятад улс нь ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүх шатанд алсын хараатай хөгжлийн бодлогын хүрээнд малчид болон үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд зориулан санхүүгийн төрөл бүрийн дэмжлэг, татаас олгон судалгаа шинжилгээ, шинэ техник, технологи нэвтрүүлэхийг урамшуулан дэмжиж ирсэн. Үүний үр дүнд Хятадын ноос, ноолуурын малын үүлдэр сайжирч, түүхий эдийн чанар гарц тогтмол нэмэгдэхийн зэрэгцээ, үйлдвэрлэгчид дотоодынхоо болон дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц хамгийн сүүлийн үеийн техник, технологи, дэлхийн хэмжээний чадварлаг боловсон хүчнийг өөртөө татан цаашид тансаг хэрэглээний зах зээлд Итали, Англи, Япон улсуудтай өрсөлдөх өөрийн брэндийг таниулах өндөр зорилтыг тавьж байна.

1. БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ ШИНЖИЛГЭЭ

1.1 Хятадын ноос, ноолуурын салбарын өнөөгийн байдал

Хятадын ноолуурын салбар сүүлийн жилүүдэд тогтмол өсөж дотоодын ноолууран бүтээгдэхүүний нийт гарц 19,300 тн болсон байна.

Жилийн дундаж өсөлт 3-4 орчим хувьтай байгаа ба цаашид өсөлтийн энэ хурдаа хадгалах хандлага ажиглагдаж байна.

График 1: Хятадын ноолуурын гарц (тн)

Эх сурвалж: Хятадын үндэсний статистикийн хороо

Хятад улс ноос, ноолуурын гол боловсруулагч улс тул дэлхийн зах зээлд түүхий эдийн үнэ тогтоох хүчтэй нөлөөтэй.

Ноолуурын гарц, боловсруулалтаар Хятад улс дэлхийд тэргүүлдэг хэдий ч дээд зэрэглэлийн тансаг хэрэглээний эцсийн бүтээгдэхүүний зах зээлд Итали, Англи, Япон улсууд манлайлж, өндөр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд нийлүүлдэг.

Хятадын ноолууран бүтээгдэхүүний салбарт жижиг дунд бизнесээс эхлээд дэлхийн хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хүртэл хэмжээ, санхүүгийн харьцангуй чадамж бүхий 2600 орчим компани үйл ажиллагаа эрхэлж байна..

Хятад улс ноосон эдлэлийн үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг бөгөөд дэлхийн ноос боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлын 35%-ийг дангаар бүрдүүлдэг. Хятад улсад сүүлийн үед ноосны гарц өсөж 2017 онд нийт 494,000 тн хүрсэн байна.

График 2: Хятадын ноосны гарц (тн)



Эх сурвалж: Хятадын үндэсний статистикийн хороо

Хятадын дотоодын үйлдвэрлэгчдийн нийт түүхий ноосны эрэлт 2017 онд 794,000 тн хүрсэн нь өмнөх оныхоос 0.25%-иар өссөн байна.

График 3: Хятадын ноос боловсруулагч үйлдвэрийн нийт эрэлт, тн



Эх сурвалж: Хятадын үндэсний статистикийн хороо

Хятад улс нь ноолууран түүхий эдийн эрэлтээр тэргүүлдэг. Хятад улс Монгол болон бусад орнуудаас жилд дунджаар 4,000 гаруй тн ноолуур хүлээн авч боловсруулдаг. Хятад улсад дэлхийн түүхий ноолуурын 90% орчим нь

төвлөрч боловсруулалтын төрөл бүрийн шатаар дамжин дэлхийн нийт ноолууран бүтээгдэхүүний экспортын 80%-ийг буцаан гаргадаг.

Өвөр Монголын ноолуур Хятадад төдийгүй дэлхийн хэмжээнд өндөр чанартайд тооцогддог буюу өнгө голдуу цагаан, цайвар, ширхэг нарийн байдаг.

Хятадын ноолуурын гарцын үзүүлэлтийг бүсчлэн харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 1: Хятадын ноолуурын гарц, бүс нутгаар

1990 он			2005 он			2015 он		
Бүс, нутаг	Гарц тн	Эзлэх %	Бүс, нутаг	Гарц тн	Эзлэх %	Бүс, нутаг	Гарц тн	Эзлэх %
Өвөр Монгол	2076	36.1	Өвөр Монгол	6395	41.4	Өвөр Монгол	8380	43.5
Шиньжян	607	10.6	Шиньжян	1285	8.3	Шэньси	1972	10.2
Шаньдун	540	9.4	Шэньси	1053	6.8	Шиньжян	1218	6.3
Шэньси	475	8.3	Шаньдун	913	5.9	Шаньдун	1217	6.3
Төвд	448	7.8	Төвд	906	5.9	Төвд	962	5

Эх сурвалж: Хятадын үндэсний статистикийн хороо

Хятад улсын хэмжээнд үйлдвэрлэгдэж буй ноолууран бүтээгдэхүүний 50 орчим хувийг Өвөр Монголд дангаар үйлдвэрлэж байгаа бөгөөд Ордос, Баяннуур, Алха, Шилийн гол мужуудад ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрүүд голчлон байршдаг.

Хятад улсад ноос, ноолуурын боловсруулах үйлдвэр байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг эдийн засгийн төрөл бүрийн арга замаар хөхиүлэн дэмжиж боловсруулах үйлдвэрийн хүчин чадал сүүлийн жилүүдэд хэт их өссөн гэсэн шүүмжлэл дагуулдаг *(1000 Ресурс судалгааны байгууллагын тайлан, 2017).*

Хятадын ноос, ноолуурын үйлдвэрлэлийн хүчин чадлын төлвийг уг чиглэлээр судалгаа хийсэн “1000 ресурс судалгааны байгууллага”-аас дараах байдлаар тооцоолжээ. Үүнд:

График 5: Хятадын ноос, ноолуурын үйлдвэрлэлийн төлөв (тн)



	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Өсөлтийн хувь		2.0%	1.6%	1.7%	2.5%	1.5%	1.8%	1.7%	1.7%	1.7%
Үйлдвэрлэл, тн	474,500	484,100	491,800	500,500	513,300	521,000	530,400	539,800	549,200	558,600

Эх сурвалж: http//:www.qianinfo.com

Хятадын ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадал нь дотоодын болон импортоор нийлүүлэгдэж буй түүхий эдийн гарцаас давж байгаа тул цаашид ч түүхий эдийн эрэлт болон үнэ өсөх хандлагатай байна.

1.2 Хятадын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн судалгаа

Хятадын ноолууран бүтээгдэхүүний зах зээлд үйл ажиллагаа эрхэлдэг 2600 гаруй компаниудаас томоохон 10 компани нь нийт зах зээлийн 75 хувийг эзэлдэг.

Хүснэгт 2: Хятадын ноолууран зах зээлийн хувь

Үйлдвэр	Зах зээлд эзлэх хувь
Inner Mongolia Erdos Resources Co., Ltd.	16.7%
Ningxia Zhongyin Cashmere International Group Co., Ltd.	12.6%
Inner Mongolia Deer Cashmere Co., Ltd.	8.5%
Ningxia Rongchang Cashmere Group Co., Ltd.	8.1%
Hebei Yu Teng Cashmere Products Co., Ltd.	6.4%
Beijing Xuelian Group Co., Ltd.	6.1%
Ningxia St. Cashmere International Enterprise Group	4.8%

Эх сурвалж: http//:www.qianinfo.com

Хятадын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн топ 10 компани нийт зах зээлийн 75 хувийг эзэлдэг тул зах зээлийн төвлөрөл дунд хэмжээтэй олигополь зах зээл гэж дүгнэхээр байна.

Хятадын зах зээлд ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг томоохон компаниудыг танилцуулбал дараах байдалтай байна.

1. ***Өвөр Монголын Ордос ресурс ХК***
   (Inner Mongolia Eerduosi Resources JSC)

Өвөр Монголын Ордос Ресурс ХК нь Хятадын хамгийн том ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа эрхэлдэг компани юм. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төрөлд ямааны ноос, ноолууран даавуу, цамц, хүрэм, ороолт зэрэг бүх л төрлийн ноолууран болон ноосон хувцасны үйлдвэрлэл худалдаанаас гадна ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шинэ техник, шинжлэх ухааны үйлдвэрлэл багтдаг. Тус компани нь Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй ба зах зээлийн үнэлгээ нь 30 тэрбум юань ба нийт 26,000 ажилчин бүхий 126 салбар компанитай болтлоо өргөжсөн байна.

Ордос групп нь Итали, Японы томоохон брэндүүдэд хагас боловсруулсан бүтээгдэхүүн, ноолууран утас, төрөл бүрийн ноолуурын орц хэмжээ бүхий даавуу нийлүүлэхийн зэрэгцээ сүүлийн жилүүдэд өөрийн нэрийн хэд хэдэн брэндийг амжилттай бий болгон эцсийн бүтээгдэхүүнийг дотоод гадаадад хүлээн зөвшөөрүүлэхээр ажиллаж байна.

1436 ERDOS 鄂尔多斯 -1980- BLUE ERDOS

Компани нь 1436, Ордос, Ордос 1980, Блю Ордос брэндүүд гарган олонд таниулсан ба Хятад улсдаа 1000 орчим, 30 гаруй улс, Лос-Анжелс, Токио, Москва, Лондон, Милан Хонгконг зэрэг дэлхийн томоохон 20 гаруй хотуудад өөрийн нэрийн барааны дэлгүүр ажиллуулахаас гадна олон улсын худалдааны долоон компаниараа дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулдаг.

Ордос ресурс ХК нь 1500 тн самнасан ноолуур, 2500 тн ноолуур будах, 2000 тн утас ээрэх, 7,000,000 ширхэг ноолууран цамц, ноолууран ороолт, алчуур зэрэг 1,500,000 ширхэг ноолууран хувцас, 1,000,000 м ноолууран даавуу, 100,000 ширхэг ноолууран хүрэм, 10 сая ширхэг ноолууран бус эрэгтэй эмэгтэй гадуур болон дотуур хувцас тус тус үйлдвэрлэх хүчин чадалтай дэлхийн хэмжээний томоохон компани *юм (Ордос группын цахим хуудас, 2018).*

Тус компани нь бараа бүтээгдэхүүний нэр хүнд, дизайнд ихээхэн ач холбогдол өгч, дэлхийн хэмжээний нэр хүнд бүхий дизайнеруудыг урьж ажиллуулдаг. Одоогоор Францын алдарт Chanel брэндийн Дизайн, уран сайхны захирал асан Gilles Dufour нь Ордос брэндийн эмэгтэй хувцасны Дизайн, уран сайхны захирлаар, Salvatore Ferragamo болон Giorgio Armani брэндүүдийн ахлах дизайнер болон дизайн уран сайхны захирлаар ажиллаж байсан Graeme Black 1436 брэндийг хариуцан Дизайн, уран сайхны захирлаар тус тус ажиллаж байна.

2. ***Жигангсү Эйсер Текстайл ХХК***
   (Jigangsu Acer Textile Co.,Ltd)

Уг компани нь 1956 онд үйл ажиллагаа эхлүүлсэн төрийн өмчит компанийн суурь дээр 2000 онд байгуулагдсан ХХК юм. *Жигангсү* Эйсер Текстайл нь ноос, ноолууран нэхмэлийн төрөл бүрийн утас, цамц үйлдвэрлэдэг. Тус компани нь жил бүр 2 сая цамц, 3000 тн ноолууран утас болон 4500 тн ноосон утас үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус компанийн борлуулалтад цахим борлуулалт томоохон байр суурь эзэлдэг.

3. ***Тэнг кашемир продуктс ХХК***
   (Teng Cashmere Products Co., Ltd)

Тус компани нь 2003 онд байгуулагдсан ба Хэбэй мужийн ноолуур боловсруулах хамгийн том үйлдвэр юм.

Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооноос шилдэг 30 ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн нэгээр шалгарсны зэрэгцээ

ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нэвтрүүлж буй шинэ техник, технологи болон түүхий эд нийлүүлэгчидтэй хамтран ашигтай харилцаатай байдгаараа нэр хүндтэй. Малчдын холбоо, нөхөрлөлтэй урт хугацаанд нягт хамтран ажиллахын зэрэгцээ түүхий эдийн чанарыг дээшлүүлэхэд анхааран дэмжлэг үзүүлсээр ирсэн.

Түүхий эдээ Өвөр Монгол, Цинхай, Ляонин мужид байршил бүхий салбар нэгжээр дамжуулан хүлээн авдаг. Компани нь нийт 50 сая юанийн хөрөнгөтэй, 800 тн ямааны арьс болон 200 тн ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай.

Тэнг кашемир үйлдвэртээ ISO9001 чанарын хяналтын системийг мөрдөхийн зэрэгцээ байгаль орчинд ээлтэй, цэвэр үйлдвэрийн зарчмыг баримтлан бараа бүтээгдэхүүнээ Итали, Европын бусад орнууд, АНУ, Ойрх дорнод болон Зүүн өмнөд Азийн орнуудад нийлүүлдэг.

Чифенг Донронг кашмир дэвэлопмент групп ХХК
(Chifeng Dongrong cashmere development Group Co., Ltd)

Өвөр Монголын өмнөд хэсэгт байрлах Хонгшан эдийн засгийн хөгжлийн бүсэд байгуулагдсан ба нийт 198,600 м.кв газартай, 48,000 м.кв талбай бүхий үйлдвэрийн байртай.

Донронг кашемир дэвэлопмент групп нь 1000 орчим ажилтантай, 300 тн ноолуур, 800 мянган ноолууран цамц, 300 мянган ноолууран ороолт үйлдвэрлэх хүчин чадалтай хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон шилдэг үйлдвэрлэгчдийн нэг юм. Компани нь чанарын хяналтын удирдлагад ихээхэн анхаардаг бөгөөд ноолууран бүтээгдэхүүний салбартаа нэр хүндтэй.

Компани нь нийт 557 сая юанийн хөрөнгөтэй ба үйл ажиллагааны үндсэн чиглэл нь ноолуур хүлээн авч боловсруулан угаах, ноосон утас болон даавуу хийх, ноолууран ороолт, ноолууран цамц үйлдвэрлэх болон ноолуур боловсруулах тоног төхөөрөмжийн судалгаа шинжилгээ юм.

Ноолуурын түүхий эдээ Өвөр Монголын Ханшан үүлдрийн ямаанаас авдаг ба нутгийн малчидтай 30 жил нягт хамтран ажиллаж ноолуурын чанар, гарцыг нэмэгдүүлэх чиглэлээр дэмжсээр ирсэн. Жилдээ нийт 600 тн дээд зэрэглэлийн Ханшан цагаан ноолуурыг малчдаас худалдан авдаг. Ханшан ямааны ноолуурын ширхэг нь 14.5-15.5 микрон ба ширхгийн урт нь 36 мм орчим байдаг.

Японы Фүкоки ХК-тай хамтран Японы сүүлийн үеийн техник, технологиор тоноглогдсон ноолууран ороолтын үйлдвэрийг байгуулсан ба жилдээ 300 мянган ноолууран ороолт үйлдвэрлэдгээс 90 орчим хувийг Японы зах зээлд гаргадаг.

4. ***Донгуан Дионг кашмир продактс ХХК***
   (Dongguan Derong Cashmere Products Co.,Ltd)

Донгуан Дионг кашемир продактс компани нь 1999 онд байгуулагдсан ба Гуандун мужийн Доунгонг хот, Далан дүүрэгт байршдаг ба гэр бүлийн жижиг үйлдвэрээс групп компани хүртэл хөгжөөд байна.

Тус компани нь сайн чанарын угаасан ноолуур, бүх төрлийн ноолууран утас, ноолуур будах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Үйлдвэрлэлийн жилийн нийт хүчин чадал 500 тн ба үйлдвэрлэлдээ байгальд ээлтэй импортын будаг хэрэглэдэг ба 200 тн багтаамжтай агуулахтай.

Зах зээлд голлон 100% ноолууран, 50% ноолуур 50% ноос, 30% ноолуур 70% ноос, 10% ноолуур 90% ноосны орц бүхий утсыг өнгөний өргөн сонголттойгоор нийлүүлдэг.

5. ***Өвөр Монголын Кинг Дийр кашемир ХХК***
   (Inner Mongolia King Deer Cashmere Co.,Ltd)

Тус компани нь 1985 онд байгуулагдсан ба Өвөр Монголын өөртөө засах орны Бугат хотод байршдаг ба Мадагаскар болон Камбож улсуудад үйлдвэрийн салбаруудыг нээсэн.
Нийт 5 сая ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай ба үүн дотор 1000 ширхэг цамц болон хүрэм, 2000 тн утас, 1 сая метр даавуу үйлдвэрлэдэг. Жил бүр 500 сая юань хөрөнгийг гарган 2000 тн сайн чанарын түүхий ноолуурыг малчдаас худалдан авдаг.

Үйлдвэрийн ажиллагчдын тоо нь 10,000 орчим, группийн бүрэлдэхүүнд борлуулалт эрхэлсэн компаниуд болон 23 салбар, 800 гаруй нэрийн барааны дэлгүүр багтдаг.

Жилийн 4 улирлын хувцас (эрэгтэй, эмэгтэй) үйлдвэрлэдэг ба нийт бүтээгдэхүүний 85 хувийг АНУ, Европ, Япон, Өмнөд Солонгос зэрэг орнуудад нийлүүлдэг.

Жилийн борлуулалтын орлого нь 1 тэрбум гаруй юань ба зөвхөн АНУ-д хийгддэг жилийн борлуулалт нь 80 сая долларт хүрдэг.

Өвөр Монголын Кинг Диир Кашмер компани нь чанарын хяналтын ISO9001, байгаль орчинд ээлтэй болон цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ISO14001, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн ISO18000 стандартуудыг хангасан Хятадын хамгийн анхны компани юм.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 100 гаруй патент эзэмшдэг бөгөөд чанарын хяналт, шинжлэх ухаан, технологийн дэвшлийг үйлдвэрт нэвтрүүлэгч байгууллага хэмээн Засгийн газрын шат шатны байгууллагаас олон удаагийн нэр хүнд бүхий шагнал, өргөмжлөлийг хүлээн авч байсан ба үйлдвэрийн 30 гаруй стандартыг боловсруулахад оролцож байсан туршлагатай, дотоодын зах зээлд танигдсан, цаашид дэлхийд танигдсан нэр хүнд бүхий брэнд гаргах зорилт тавин ажиллаж байна.

1.3 Дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөөний хүчин зүйлс

Хүчин зүйлс	Хятадын зах зээлийн онцлог
Үнэ	Хятадын зах зээлд одоогоор бусдаас эрс ялгаран гарч олонд танигдсан брэнд цөөн байна. Харин нийт зах зээлийн дийлэнх хэсэгт нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүний ноолуурын агууламж голдуу 25-35 хувийн хооронд байна. Тиймээс бараа бүтээгдэхүүний үнийг бууруулах замаар хэрэглэгчдээ татах бодлого түгээмэл байдаг.
Борлуулалт болон түүхий эдийн суваг	Хятадын ноолууран бүтээгдэхүүний зах зээлийн борлуулалтын суваг нь голдуу шууд худалдаа, агентаар дамжсан худалдаа болон экспортод гаргах гэсэн хандлагатай байна. Хятадын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч томоохон компаниуд түүхий эдийн болон борлуулалтын иж бүрэн сувагтай болохыг төлөө тууштай өрсөлдөж байна. Үүний нэг жишээ нь Өвөр Монголын Ордос Ресурс компани юм. Тус компани нь Хятадын нийт түүхий ноолуурын 30 хувийг өөрийн сувгаар хүлээн авч шат шатанд боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж байна.
Бүтээгдэхүүн үйлчилгээний чанар	Ноолууран бүтээгдэхүүний чанарыг хэрэглэгчид тухайн бүтээгдэхүүнд эзлэх ноолуурын агууламжаар тодорхойлох хандлагатай байна. Хятадын дундаж орлоготой, тансаг чанартай бүтээгдэхүүн хэрэглэх хүсэлтэй хэрэглэгчид нэмэгдэж буйтай холбоотой үйлдвэрлэгчид дотоодын зах зээлд нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүний чанарт ихээхэн анхаарах, хэрэглэгчдэд сурталчлахад анхаарах болсон.
Брэнд	Ноолууран бүтээгдэхүүний үнэлэмжийн хамгийн чухал үзүүлэлт нь брэнд болоод байна. Хятад Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Дэлхийд гарах” хөтөлбөрийн хүрээнд дотоодын ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг брэнд бүтээгдэхүүнээ дотоодын болон олон улсын зах зээлд гаргах, сайн чанарын техник, тоног төхөөрөмжтэй болоход зориулан хөнгөлөлттэй зээл, тус салбарт ажиллаж буй ажиллагсдын нийгмийн даатгалын хөнгөлөлт, эцсийн

	бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргах бол татварын буцаан олголт, төрөл бүрийн татаас өгөх замаар дэмжиж байна.

2. ТҮГЭЭМЭЛ ҮЙЛДВЭРЛЭДЭГ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР-ҮНИЙН ХАМААРЛЫН СУДАЛГАА

Хятадад ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй компаниудыг 3 бүлэгт хувааж үзэж болохоор байна. Үүнд:

Хүснэгт 3: Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн ангилал

	Онцлог	Компаниуд
Бүлэг 1	Зах зээлд эзлэх хувь өндөр, үйлдвэрлэлийн иж бүрэн шатлалыг хамарч үйл ажиллагаа явуулдаг, дээд зэрэглэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болох, дотоодын тансаг хэрэглээний зах зээлд байр суурь эзлэх зорилго тавин үйл ажиллаа явуулдаг.	-(Inner Mongolia Erdos Resources) -(Ningxia Zhongyin Cashmere International Group Co., Ltd)
Бүлэг 2	Харьцангуй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн шатанд анхаардаг, дотоодын зах зээлд хэрэглэгчдэд танигдсан компаниуд, хэрэглэгчдийн янз бүрийн орлогын түвшинд тааруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.	-(Inner Mongolia King Deer Cashmere Co., Ltd) -(Hebei Yu Teng Cashmere Products Co., Ltd)
Бүлэг 3	Зах зээлд бага хувь эзэлдэг, танигдаагүй жижиг дунд үйлдвэрүүд болон энэ салбарт үйл ажиллагаа эхлүүлж буй үйлдвэрүүд	Нийт 2600 орчим компани байна

Нэгдүгээр бүлэгт хамаарагдаж буй Өвөр Монголын Ордос ресурс компани нь дотоодын зах зээлд харьцангуй танигдаад байна.

Хятадын дундаж давхаргын хэрэглэгчдийн тансаг бүтээгдэхүүний хэрэглээ өсөж байгаатай холбоотойгоор 1436, Блю Ордос, Ордос зэрэг хэд хэдэн брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг, үнийн хувьд дотоодын үйлдвэрлэгч дотроо хамгийн үнэтэйд тооцогдож байна.

Харин хоёрдугаар бүлгийн буюу Кинг Дийр Кашемир зэрэг компани нь сайн чанарын ноос, ноолууран бүтээгдэхүүнээс гадна, үнэ хямд бүтээгдэхүүнийг ч хэрэглэгчдийн эрэлтэд тааруулан үйлдвэрлэдэг.

Дотоодын хэрэглэгчид нь бүтээгдэхүүний чанарт түлхүү анхаардаг болсон тул дотоодын зах зээлд харьцангуй сайн чанарын бүтээгдэхүүнийг харьцангуй өндөр үнээр нийлүүлдэг. Харин гадаадын захиалагчдын хүсэлтээр дунд болон доогуур зэрэглэлийн түүхий эдийг ашиглан хямд үнийн дүнтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг. Үүний нэг жишээ нь тухайн компани нь Маркс Спенсер брэндийн нэрээр гаргадаг 100 хувийн ноолуур цамц нь 100 орчим ам.долларын үнэтэй борлуулагдаж байна.

Гуравдугаар бүлэгт хамаарах үйлдвэрлэгчид нь голдуу үнээр өрсөлддөг буюу бүтээгдэхүүний чанар дунд болон доогуур, ноолуурын агууламж харьцангуй бага бүтээгдэхүүнийг хямд үнээр зах зээлд нийлүүлэхийг зорьдог.

Дотоодын үйлдвэрлэгчдийн түгээмэл нийлүүлдэг бүтээгдэхүүний үнийг гарган харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 4: Ноолууран бүтээгдэхүүний үнийн судалгаа

/Юань/

Бүтээгдэхүүн		**Брэнд, бүлэг**		
		Бүлэг 1. Ордос брэнд	Бүлэг 2. Кинг Дийр брэнд	Бүлэг 3. Танигдаагүй брэндүүд
Пальто	Эрэгтэй	24 000~30 000	4 500~6 000	2 600~5 200
	Эмэгтэй	22 000~29 000	4 700~6 000	1 800~3 700
Свиттер цамц	Эрэгтэй	6 500~11 000	1 500~3 000	750~1 100
	Эмэгтэй	6 000~10 000	1 400~2 700	380~900
Өмд		4 500~6 000	1 400~4 300	200~500
Даашинз		8 000~16 000	1 300~3 000	500~1’200
Майк			1 000~1 300	300~800
Алчуур, ороолт		3 000~6 000	450~900	250~400
Бээлий				70~90
Хөнжил		22 000~32 000		

Эх сурвалж: Үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн борлуулах онлайн сувгууд

3. ХЯТАДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

3.1 Зах, зээлийн багтаамж, цаашдын төлөв

Хятадын 1,3 тэрбум хүн ам нь ноос, ноолууран бараа бүтээгдэхүүний хэрэглээний асар томоохон зах зээл билээ. Хятадын хувцасны зах зээлийн хэмжээг Хонконгийн Эйч Кей Ти Ди Си судалгааны байгууллагаас 2016 онд нийт 1144.4 тэрбум юаниар үнэлсэн бөгөөд энэ дүн цаашид өсөн 2019 онд 1370.4 тэрбум юань хүрэх төлөвтэй. Үүнээс 2016 онд Хятад улсад 4.392 тэрбум юанийн амьтны гаралтай ноос, ноолууран хувцас бэлэн бүтээгдэхүүнийг импортоор авсан байна. Үүнд олон улсын худалдааны бараа бүртгэлийн HS код системийн дагуу хонины ноос болон ямааны ноолууран бүтээгдэхүүний импортын бүртгэлийг тусад нь бус “амьтны гаралтай ноос болон ноолууран бүтээгдэхүүн” хэсэгт тэмээ, лама гөрөөс, сарлаг болон туулайн ноос зэрэг амьтны гаралтай бусад бүтээгдэхүүнтэй хамт бүртгэдэг. Ингээд жил бүр Хятадын зах зээлд гадаад улсаас нийлүүлэгдэж буй ноос, ноолууран бүтээгдэхүүний хэмжээг (2016 он) үзүүлбэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5: Амьтны гаралтай ноос, ноолууран бүтээгдэхүүний импорт

HS код	Хувцасны төрөл зүйл	Нийт үнийн дүн /сая юань/
610210	Эмэгтэй болон охидын цув, дундаж урттай хүрэм, нөмрөг, анарокс	41.73
610331	Эрэгтэй болон хөвгүүдийн сүлжмэл хүрэм, цамц (амьтны гаралтай ноос болон ноолуур)	57.24
610341	Эрэгтэй болон хөвгүүдийн сүлжмэл өмд, мөрөвчтэй өмд, богино өмд (амьтны гаралтай ноос болон ноолуур)	18.11
610431	Эмэгтэй болон охидын сүлжмэл хүрэм, цамц (амьтны гаралтай ноос болон ноолуур)	53.15
610441	Эмэгтэй болон охидын сүлжмэл даашинз (амьтны гаралтай ноос болон ноолуур)	79.73
610451	Эмэгтэй болон охидын сүлжмэл банзал (амьтны гаралтай ноос болон ноолуур)	13.21
610461	Эмэгтэй болон охидын сүлжмэл өмд, мөрөвчтэй өмд, богино өмд (амьтны гаралтай ноос болон ноолуур)	10.44
611011	Битүү болон задгай энгэртэй сүлжмэл ноосон цамц	732.82

611012	Битүү болон задгай энгэртэй сүлжмэл ямааны ноолууран цамц	257.05
611019	Битүү болон задгай нарийн ноос, ноолууран цамц (ямааны ноолуур үүнд орохгүй)	60.33
611691	Сүлжмэл бээлий (амьтны гаралтай ноос болон ноолуур)	3.43
611710	Сүлжмэл ороолт, алчуур	94.61
620111	Эрэгтэй болон хөвгүүдийн оёмол пальто, цув, дундаж урттай хүрэм, нөмрөг, анарокс (амьтны гаралтай ноос болон ноолуур)	223.46
620191	Эрэгтэй болон хөвгүүдийн цана, салхины зориулалттай анарокс (амьтны гаралтай ноос болон ноолуур)	80.80
620211	Эмэгтэй болон охидын оёмол пальто, цув, дундаж урттай хүрэм, нөмрөг, анарокс (амьтны гаралтай ноос болон ноолуур)	702.04
620291	Эмэгтэй болон охидын цана, салхины хамгаалалтын зориулалттай оёмол анарокс (амьтны гаралтай ноос болон ноолуур)	31.69
620311	Эрэгтэй болон хөвгүүдийн оёмол хослол (амьтны гаралтай ноос болон ноолуур)	317.35
620331	Эрэгтэй болон хөвгүүдийн оёмол хүрэм, (амтны гаралтай ноос болон ноолуур)	439.02
620341	Эрэгтэй болон хөвгүүдийн оёмол өмд, мөрөвчтэй өмд, богино өмд (амьтны гаралтай ноос болон ноолуур)	229.05
620411	Эмэгтэй болон охидын оёмол хослол (амьтны гаралтай ноос болон ноолуур)	0.97
620421	Эмэгтэй болон охидын оёмол хослол (амьтны гаралтай ноос болон ноолуур)	0.15
620431	Эмэгтэй болон охидын оёмол хүрэм (амьтны гаралтай ноос болон ноолуур)	161.54
620441	Эмэгтэй болон охидын оёмол даашинз (амьтны гаралтай ноос болон ноолуур)	136.40
620451	Эмэгтэй болон охидын оёмол банзал (амьтны гаралтай ноос болон ноолуур)	52.56
620461	Эмэгтэй болон охидын оёмол өмд, мөрөвчтэй өмд, богино өмд (амьтны гаралтай ноос болон ноолуур)	81.28
621420	Оёмол ороолт, алчуур (амьтны гаралтай ноос болон ноолуур)	473.32
621600	Бүх төрлийн оёмол бээлий (амьтны гаралтай ноос болон ноолуур)	44.76

Эх сурвалж: https://www.trademap.org

Хонконгийн Эйч Кей Ти Ди Си судалгааны байгууллагын дүгнэлтээр Хятадын хувцасны зах зээлд 2 төрлийн импортын бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байгаа нь өндөр орлого, тансаг хэрэглээ бүхий хэрэглэгчдэд зориулсан өндөр чанартай брэнд бүтээгдэхүүн эсвэл болон дундаж орлоготой хэрэглэгчдэд зориулсан Zara, H&M, Uniqlo гэх мэт дундаж үнэтэй, голдуу залуу хэрэглэгчдэд зориулсан бүтээгдэхүүн юм.

Харин бага орлого бүхий иргэдэд зориулсан хямд хувцас, бүтээгдэхүүнийг Хятадын дотоодын үйлдвэрлэгчид голчлон хангадаг бөгөөд гадаад үйлдвэрлэгчид энэхүү зах зээлд төдийлөн нэвтрэх боломж хомс байдаг байна.

<u>Эмэгтэй хувцасны зах зээлийн багтаамж</u>

Евромонитор судалгааны байгууллагын тооцооллоор (2017) Хятадын эмэгтэй хувцасны зах зээлийн нийт багтаамж 2016 онд 872.8 тэрбум юань, цаашид өссөөр 2021 онд 963.2 тэрбум юаньд хүрэх төлөвтэй байна.

Ажил эрхэлж буй нийт эмэгтэйчүүдэд эзлэх оффисын ажилтны хувь өсөхийн хэрээр, тэдний орлого өсөж худалдан авах чадвар сайжирч байгаа тул дунд болон дээгүүр орлого бүхий, 30-45 насны ажил хэрэгч эмэгтэйчүүдэд зориулсан тансаг хэрэглээний чанартай хувцасны зах зээл ирээдүйтэй харагдаж байна.

Гадаад улсаас импортолсон амьтны гаралтай ноос, ноолууран хувцасны худалдан авалт 2016 онд 3 тэрбум орчим юань байна.

<u>Эрэгтэй хувцасны зах зээлийн багтаамж</u>

Евромонитор судалгааны байгууллагын тооцооллоор (2017) Хятадын эрэгтэй хувцасны зах зээлийн нийт багтаамж 2016 онд 513.1 тэрбум юань байсан бол цаашид өссөөр 2021 онд 551.5 тэрбум юань хүрэхээр байна.

Хятад эрэгтэйчүүд хувцас худалдан авахдаа баримталдаг дулаан, эвтэйхэн зэрэг энгийн шаардлага тавьдаг байсан уламжлалт хандлага халагдаж байна. Тэд чанартай, брэндлэг бүтээгдэхүүн худалдан авахыг хүсэх болжээ.

Хүүхдийн хувцасны зах зээлийн багтаамж

Хятадын статистикийн хорооны мэдээгээр 2017 оны байдлаар 15 хүртэлх насны хүүхдийн тоо 230 сая байна. Евромониторингийн тооцооллоор Хятадын хүүхдийн хувцасны зах зээлийн нийт багтаамж 2016 онд 145 тэрбум юань байсан бол жилийн өсөлт нь дунджаар 7% орчим байна. Хэдийгээр Хятадад хувцсыг цахим сүлжээгээр захиалан авах хандлага эрс нэмэгдэж байгаа хэдий ч хүүхдийн хувцас, хэрэглэлийг хэрэглэгчид дэлгүүрээс өөрийн биеэр шалгаж, мэдэрч үзсэний үндсэн дээр худалдан авах хандлага түгээмэл байна. Хүүхдийн хувцасны түүхий эд, бараа материалын аюулгүй байдал нь шийдвэр гаргалтад голчлон нөлөөлдөг байна.

Ажлын хувцасны зах зээл

Хятад улс нь олон сая ажилчид бүхий томоохон үйлдвэрлэгч улс тул ажлын хувцасны зах зээлийн багтаамж өндөртэй. Хятадын үндэсний хувцасны холбооноос нийт 19 салбарын үйлдвэрлэл ажлын хувцас өмсөх шаардлага тавьдаг, зах зээлийн багтаамж нь жилдээ 300-400 тэрбум юань хүрдэг. Хятад улсад одоогоор 30,000 орчим ажлын хувцас үйлдвэрлэгч үйл ажиллагаа явуулж байгаа, хэрэглэгчид загвар, чанарт ихээхэн анхаардаг болсон байна. Үүнийг дагаад сайн чанарын ажлын хувцасны брэнд бүтээгдэхүүний зах зээл ирээдүйтэй байх боломжтой.

3.2 Хятадын зах зээлд нэвтрэх боломж-Импортын шинжилгээ

Дэлхий нийтийг хамарсан удаа дараагийн эдийн засаг, санхүүгийн хүндрэлээс улбаалан экспортын орлого буурах болсон тул Хятадын үйлдвэрлэгчид тогтмол өсөж буй өөрийн дотоодын зах зээлд анхаарах болсон. Хятадын тансаг хэрэглээний хувцасны зах зээлийг Франц, Герман, Итали, Япон, АНУ, Англи, Солонгосын брэндүүд эзэлдэг бол Хонконг болон Тайваны брэндүүд зах зээлийн дундаж орлоготой хэсэгт, харин дотоодын компаниуд голдуу дунджаас бага орлоготой хэрэглэгчдэд бараагаа нийлүүлдэг.

Монгол Улсаас Хятад улсад экспортоор нийлүүлсэн амьтны гаралтай ноос, ноолууран хувцас, бүтэгдэхүүний хэмжээ, түүний Хятадын импортод эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6: Монгол улсаас Хятад улсад нийлүүлсэн ноос, ноолууран бүтээгдэхүүн, Хятадын нийт импортод эзлэх хувь

/мян ам.доллар/

HS код	Хувцасны төрөл зүйл	Монголоос Хятад руу экспортолсон бүтээгдэхүүний үнийн дүн			Хятадын нийт импорт	
		2015 он	2016 он	2017 он	2017 он	Монголын экспортын эзлэх хувь
610210	Эмэгтэй болон охидын цув, дундаж урттай хүрэм, нөмрөг, анарокс	45	44	172	7070	0.02%
610331	Эрэгтэй болон хөвгүүдийн сүлжмэл хүрэм, цамц (амьтны гаралтай ноос болон ноолуур)	4	10	2	8495	~0%
610341	Эрэгтэй болон хөвгүүдийн сүлжмэл өмд, мөрөвчтэй өмд, богино өмд (амьтны гаралтай ноос болон ноолуур)	0	13	4	4019	~0%
610431	Эмэгтэй болон охидын сүлжмэл хүрэм, цамц (амьтны гаралтай ноос болон ноолуур)	6	27	4	6215	~0%
610441	Эмэгтэй болон охидын сүлжмэл даашинз (амьтны гаралтай ноос болон ноолуур)	12	9	15	12108	~0%
610451	Эмэгтэй болон охидын сүлжмэл банзал (амьтны гаралтай ноос болон ноолуур)	0	3	1	1966	~0%
610461	Эмэгтэй болон охидын сүлжмэл өмд, мөрөвчтэй өмд, богино өмд (амьтны гаралтай ноос болон ноолуур)	3	19	16	2315	~0%
611011	Битүү болон задгай энгэртэй сүлжмэл ноосон цамц	467	52	50	129447	~0%
611012	Битүү болон задгай энгэртэй сүлжмэл ямааны ноолууран цамц	0	34	135	48724	~0%
611019	Битүү болон задгай энгэртэй сүлжмэл амьтны нарийн ноос, ноолууран цамц (ямааны ноолуур үүнд орохгүй)	48	52	151	10196	0.01%
611710	Сүлжмэл ороолт, алчуур	40	72	69	17980	~0%
620111	Эрэгтэй болон хөвгүүдийн оёмол пальто, цув, дундаж урттай хүрэм, нөмрөг, анарокс (амьтны гаралтай ноос болон ноолуур)	8	22	9	36658	~0%

620211	Эмэгтэй болон охидын оёмол пальто, цув, дундаж урттай хүрэм, нөмрөг, анарокс (амьтны гаралтай ноос болон ноолуур)	18	39	1	115474	~0%
621420	Оёмол ороолт, алчуур (амьтны гаралтай ноос болон ноолуур)	10	43	71	73172	~0%

Эх сурвалж: https://www.trademap.org

Дээрх хүснэгтээс харахад Монголын үйлдвэрлэгчдийн хувьд Хятад улс нь ноос, ноолууран бүтээгдэхүүний маш том зах зээл болж нийлүүлж буй бараа бүтээгдэхүүнээ өсгөх бүрэн боломжтой байна. Өөрөөр хэлбэл ноос, ноолууран хувцасны төрөл зүйл тус бүрийн экспорт нь Хятадын гадаадаас авдаг энэ төрлийн импортын 1%-д ч хүрэхгүй байна.

4. ХЯТАДЫН НООС, НООЛУУР БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРТ АШИГЛАЖ БУЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ГАРАЛ ҮҮСЛИЙН СУДАЛГАА

Хятадын ноос, ноолууран бүтээгдэхүүн боловсруулагчид үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөө сүүлийн жилүүдэд эрчимтэй сайжруулан дэлхийн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг ашигладаг болжээ. Үйлдвэрлэгчдийн тоног төхөөрөмжийг сайжруулахад Засгийн газраас баримталж буй төрөл бүрийн дэмжлэг чухал үүрэгтэй.

Хятад улс 2014-2016 онд нийт 1,9 тэрбум ам.долларын ноос, ноолуур боловсруулах тоног төхөөрөмжийг гадаад зах зээлээс худалдан авчээ. Үүнд Итали улсаас 501,8 сая ам.долларын өртөг бүхий худалдан авалт хийсэн нь тоног төхөөрөмжийн импортын 26%, Герман улсаас 546,7 сая ам.долларын өртөг бүхий худалдан авалт хийсэн нь 29%-ийг тус тус эзэлж байна. Дараах хүснэгтээр хилээр орж ирсэн ноос, ноолуур боловсруулах төрөл бүрийн тоног төхөөрөмжийн задаргааг харьцуулан харуулж байна. Үүнд:

Хүснэгт 7: Хятадын ноос, ноолуур боловсруулах тоног төхөөрөмжийн импортын судалгаа

/2014-2016 он, мян ам.доллар/

HS код	Машин, тоног төхөөрөмжийн төрөл	Хятадын импортоор авсан тоног төхөөрөмж	Итали улсаас авсан тоног төхөөрөмж		Герман улсаас авсан тоног төхөөрөмж	
			Дүн	Хувь	Дүн	Хувь
844540	Ороох машин	770,137	288,345	37%	279,978	36%
844511	Сүлжмэлийн утас бэлдэх самнах машин	188,158	112,529	60%	159,482	85%
844519	Сүлжмэлийн утас бэлдэх машин (самнах, ноос, ноолуур зулах машиныг оролцуулахгүй)	72,911	27,961	38%	27,249	37%
844530	Сүлжих, ороох машин	69,462	14,421	21%	20,023	29%
844590	Сүлжмэл утас бэлдэх машин	125,242	13,050	10%	20,093	16%
844513	Зулах, савах машин	44,374	7,656	17%	19,468	44%
844520	Ээрэх машин	603,053	30,853	5%	14,854	2%
844512	Ноос, ноолуур савах машин	39,340	6,987	18%	5,564	14%
Дүн		1,912,677	501,802	26%	546,711	29%

Эх сурвалж: https://www.trademap.org

Итали, Герман улсууд нь ноос, ноолуур боловсруулах тоног төхөөрөмжөөр дэлхийд тэргүүлэгч улсууд юм.

Нэхмэлийн төрөл бүрийн машин тоног төхөөрөмжийг голчлон Герман, Итали, Япон улсаас худалдан авсан байна. Хилээр орж ирсэн тус төрлийн машин тоног төхөөрөмжийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 8: Хятадын ноос, ноолуур боловсруулах тоног төхөөрөмжийн (нэхмэлийн) импортын судалгаа

/2014-2016 он, мян ам.доллар/

HS код	Машин, тоног төхөөрөмжийн төрөл	Хятадын импорт-оор авсан тоног төхөө-рөмж	Герман улсаас авсан тоног төхөөрөмж		Итали улсаас авсан тоног төхөөрөмж		Япон улсаас авсан тоног төхөөрөмж	
			Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
844720	Хавтгай нэхэлтийн машин; оёдол холбох машин	921,129	618,935	67%	85,546	9%	293,624	32%
844712	Битүү нэхэлтийн машин, цилиндрийн диаметр > 165 мм	78,044	26,561	34%	17,987	23%	22,178	28%
844790	Давхар хольцтой утас хийх машин	147,910	8,732	6%	2,300	2%	17,112	12%
844711	Битүү нэхэлтийн машин, цилиндрийн диаметр <= 165 мм	111,340	4,695	4%	618	1%	31	0%
ДҮН		1,258,423	658,923	52%	106,451	8%	332,945	26%

Эх сурвалж: https://www.trademap.org

Хятад улс нь 2014-2016 оны хооронд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн эцсийн шатанд хэрэглэгддэг 1,2 тэрбум долларын өртөг бүхий тоног төхөөрөмж импортолж авсан байна. Үүнд Герман улсаас хамгийн их буюу 658 сая ам.долларын машин, тоног төхөөрөмж худалдан авсан нь нийт худалдан авалтын 52%, харин Япон улсаас 332 сая ам.долларын өртөг бүхий машин, тоног төхөөрөмж авсан нь нийт худалдан авалтын 26%-ийг тус тус эзэлж байна.

5. ХЯТАД ХЭРЭГЛЭГЧДИЙН ОНЦЛОГ, БОРЛУУЛАЛТЫН СУВАГ

Хэрэглэгч төвтэй дэлхийн томоохон компаниуд цаашид зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхийн тулд Хятадын эдийн засгийн хурдацтай өсөлтөд тулгуурлах шаардлагатай гэдгийг нэгэнт хүлээн зөвшөөрсөн.

Гэхдээ энэхүү өсөлтийн хүчийг ашиглахын тулд Хятадын хэрэглэгчдийн хэрэглээг тодорхойлж буй эдийн засаг, нийгэм болон хүн ам зүйн хүчин зүйлсэд гарч буй өөрчлөлт хөдөлгөөнийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Эдийн засаг нь 2000 оноос 2010 онд гурав дахин өссөн Япон улсыг гүйцэн түрүүлснээр дэлхийд хоёрдугаарт орох болсон
- Хятадын эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр нь хөрөнгө оруулалт байсан бол хувийн хэрэглээ дараагийн 10 жилд Хятадын эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр болох хандлагатай.
- МакКензи компанийн тооцоогоор Хятадын эдийн засаг 2020 онд 2010 оны үеэс дахин 2 дахин нэмэгдэх хэдий ч нэг хүнд ногдох орлого харьцангуй бага түвшинд буюу 9000 ам.долларын түвшинд байна

Хятадын 12 дугаар 5 жилийн хөгжлийн төлөвлөгөөнд эдийн засгийн өсөлтийг хэвээр хадгалах зорилтыг тавьсан ба тэр дундаа хувийн хэрэглээг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарах хандлагатай байсан.

Хятадын хүн ам өнөөг хүртэл нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн даатгалын найдвартай систем байдаггүйгээс хамаарч олсон орлогоо зарцуулахаас илүү хадгалах хандлагатай байдаг. Хэрэв Засгийн газраас дээрх асуудлыг шийдвэл Хятадын дотоодын хэрэглээ цаашид улам өсөж эдийн засгийн өсөлтийг дэмжих бүрэн боломжтой юм.

5.1 Хятад хэрэглэгчдийн орлого, хэрэглээний хандлага

Хятад хэрэглэгчдийн эдийн засгийн чадавх сайжирч, орлого нь дараах онцлогтой өсөж байна. Үүнд:

- Хятадын хотын хэрэглэгчдийн нэг хүнд ногдох татвар, хураамжийн дараах орлого 2010 оноос 2020 он гэхэд хоёр дахин нэмэгдэх буюу 8000

ам.доллар хүрч өсөх төлөвтэй байна (МакКензи, 2017). Энэ нь өнөөгийн Өмнөд Солонгос улстай ойролцоо түвшин юм.

- Хятад улс даяар иргэдийн орлогын түвшин зөрүүтэй хэвээр байх хэдий ч орлогын өөр өөр түвшинд хамаарах хүн амын тоо нэлээд өөрчлөгдөх хандлагатай байна. Нийт хот суурин газрын хэрэглэгч дүнд эзлэх дундаж хэрэглэгч өрхийн тоо эрс нэмэгдэн нийт хэрэглэгчдийн 50 орчим хувийг бүрдүүлэхээр байна.

График 6: Хятадын хот суурины өрхийн орлогын өөрчлөлтийн таамаг



Эх сурвалж: Мак-кейнзи судалгааны байгууллагын тайлан

- Хятадын бага орлоготой хэрэглэгчид буюу татвар хураамжийн дараах өрхийн орлого 6,000-16,000 ам.доллар байх иргэдийн орлого нэмэгдэн 2020 онд дундаж орлого бүхий бүлэг рүү шилжинэ (МакКензи, 2017). Хотын хэрэглэгчдийн 51%-ийг 2020 онд бүрдүүлэх дундаж давхарга тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүн хэрэглэх сонирхол өндөртэй байна.
- Жилийн орлого нь 34,000 ам.доллар болон түүнээс дээш чинээлэг өрхийн нийт хотын хэрэглэгчдийн тоо 2020 оны байдлаар 21 саяд хүрэхээр байна (МакКензи, 2017).
- Дундаж орлоготой иргэдийн 85 орчим хувь нь Хятадын хамгийн чинээлэг 100 орчим хотод суурьшин амьдарч байна. Тиймээс бараа

бүтээгдэхүүн нийлүүлэх бол орлого өндөр дээрх хотуудад түлхүүтэй чиглэх эсэхээ бизнесийн загвартаа тусгах шаардлагатай.

График 7: Хятад өрхийн хэрэглээний бүтэц



Эх сурвалж: Мак-кейнзи судалгааны байгууллагын тайлан, 2017

Дээрх хүснэгтээр Хятадын хэрэглэгчдийн хэрэглээний бүтэц 2020 оны төсөөллийг харуулсан байна. Графикт харуулсан байр орон сууцнаас хүнс хүртэлх нийт 5 төрлийн хэрэглээ нь үндсэн хэрэглээний төрөлд багтана. Харин хувийн барааны хэрэглээгээс эхлэн спортын хэрэгсэл, соёл спортын үйлчилгээ, боловсрол, тээвэр, харилцаа холбооны хэрэглээ нь үндсэн хэрэглээнээс давсан хэрэглээ юм. Хятадын дундаж давхаргын хэрэглэгчдийн хэрэглээнд үндсэн барааны хэрэглээний хувь буурч илүү тансаг чамин бараа үйлчилгээний эрэлт нэмэгдэх хандлагатай байна.

5.2 Дундаж давхаргын хэрэглэгчдийн худалдан авалтын зан төлөв:

- Орлого нь нэмэгдэж байгаагаас үл хамааран прагматик хэвээр байна. Тэд аливаа шийдвэр гаргахаас өмнө эргэцүүлэн бодож, үнэлэлт

дүгнэлт хийдэг. Тэд “ухаантай” худалдан авагчид ба юуны түрүүнд тухайн бараа нь илүү өндөр үнэ төлөхүйц чанар, загвар зэрэг бусад шалтгаан байгаа эсэхийг бодож тунгаадаг. Үүний дараа тухайн барааг ямар сувгаар илүү хямд авах боломжтойг харьцуулан судлах хандлагатай.

- Хувь хүний онцлогт тохирсон эсэхэд ач холбогдол өгнө.Хятад худалдан авагчид бараа бүтээгдэхүүн сонгохдоо өөрт нь хэр тохирох, хэрэгцээ шаардлагыг нь хангаж байгаа эсэхэд ихээхэн ач холбогдол өгдөг болжээ. Тухайлбал, хувцас худалдан авах бол энэ хувцасны брэнд тухайн хүний нийгмийн статус, хувь хүнийг илэрхийлэх эсэхэд анхаардаг.
- Брэндэд үнэнч болно. Хятад иргэдийн орлого нэмэгдэхийн хэрээр ялангуяа дундаж болон чинээлэг давхаргын хэрэглэгчид тансаг зэрэглэлийн брэнд бүтээгдэхүүнийг туршиж үзэн, таалсан тохиолдолд цаашид тууштай хэрэглэн брэндэд үнэнч болох боломжтой.
- Худалдан авалт хийх хандлага нь өөрчлөгдөх буюу дэлгүүрт олон цаг өнгөрөөхөөс бусад худалдан авалт хийх сувгийг эрэлхийлэн туршиж үзэхийг эрхэмлэх

Хятадын томоохон хотуудын хүн амын нягтрал нэмэгдэхийн хэрээр худалдан авагчид өөрийн тав тухыг эрэлхийлэн бараа бүтээгдэхүүнээ цахим хэрэгслээр дамжуулан хүргүүлэн авах хандлага нэмэгдэж байна. Цаашид энэ хандлага нэмэгдэх төлөвтэй байгаа тул тус улсын зах зээлд нэвтрэх бол цахим сүлжээгээр дамжуулан бараа бүтээгдэхүүн борлуулах нэг суваг байдгийг санах шаардлагатай.

График 4: Хятадын интернет худалдаа



Эх сурвалж: China internet watch

5.3 Хүн ам зүйн бүтцээс хамааралтай худалдан авалтын зан төлөв

Хятадын ахмад үеийн хэрэглэгчдийн хандлага өөрчлөгдөж байна:Хүн ам нь хөгширч байгаа буюу иргэдийн дундаж нас нь 2010 онд 34 байснаа 2020 онд 37 болж өсөх ба 65 болон түүнээс дээш настай иргэдийн нийт хүн амд эзлэх хувь мөн хугацаанд 10 хувиас 15 хувь болж өсөхөөр байна. Энэ нь өнөөгийн өндөр хөгжилтэй Герман 31%, Япон 34% зэрэг улсуудтай харьцуулахад залуу үед ирэх эдийн засгийн ачаалал харьцангуй бага байгаа үзүүлэлт юм.

Хятадын шинэ үеийн ахмадууд нь өмнөх үеийн ахмадуудаасаа худалдан авах зан төлөв өөр байгаа нь ажиглагдаж байна. Хятадын 55 наснаас дээш ахмадууд 1960-70 оны соёлын хувьсгалын цаг үеийн эдийн засгийн бэрхшээлийг туулсан ба орлогын тал хүртэлх хувийг хадгалах, үндсэн хэрэглээнээс илүү зардал гаргахгүй байх хандлагатай байсан.

Харин 2020 болон түүнээс цааш үеийн Хятадын ахмадууд өмнөх үеийн ахмадуудаас илүү тансаг хэрэглээний бараа үйлчилгээ хэрэглэх сонирхолтой байх юм.

Иймд Хятадын зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр орох гэж байгаа компаниуд энэ боломжийг ашиглан үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх боломжтой байна.

Залуучууд хожуу гэрлэх болсон: Хятадын эдийн засгийн өсөлт, өрхийн орлого нэмэгдсэнтэй холбоотой Хятад хүмүүс боловсролдоо хөрөнгө оруулах хандлага нэмэгдэж байна.

Дунд боловсрол эзэмшигчдийн 25 хувь нь 2010 онд дээд боловсролын байгууллагад суралцаж эхэлж байсан бол энэ үзүүлэлт 2020 онд 40 хувь болж өсөхөөр байна.

Сайн боловсрол, сайн ажлын байртай болохын тулд Хятадын залуучууд гэр бүл зохиох хугацааг хойшлуулж байна.

Хятад эмэгтэйчүүд 2000 онд дунджаар 24 настайдаа анхны хүүхдээ төрүүлж байснаас 2010 онд 27 болж өссөн байна. Хэрэв энэ хандлага цаашид үргэлжилбэл 2020 онд дунджаар 30 настайдаа анхны хүүхдээ төрүүлдэг болно. Энэ нь амралт, зугаалга зэрэг зүйлсэд залуучууд мөнгө зарцуулах ба чөлөөт хувцасны зах зээлийн эрэлт өсөх хандлагыг илэрхийлдэг.

Бие даасан орлоготой эмэгтэйчүүдийн тоо өсөж байна:
Хятад улсын нэг хүүхэд бодлогын нөлөөгөөр хүйсийн тэнцвэрт байдал алдагдсан ба 2020 он гэхэд 25-34 насны нийт эмэгтэйчүүдэд ноогдох 13 сая эрэгтэй илүүдэлтэй байх юм.

Хэдийгээр эрэгтэй хүүхдийг илүүд үзэх хандлага Хятад гэр бүлүүдэд байгаа хэдий ч нийгэмд эзлэх эмэгтэйчүүдийн байр суурь ихээр нэмэгдэж байна.

Нийт эмэгтэйчүүдийн 67 хувь нь хөдөлмөр эрхэлдэг ба энэ үзүүлэлт Энэтхэгт 33, Японд 48, АНУ-д 58 хувь байдаг байна.

Нэг хүүхэд бодлогын хүрээнд өмнө нь ажил хийлгүйгээр зөвхөн гэр бүлийн бусад гишүүдээ асрах үүрэгтэй байсан охидууд хөвгүүдийн адил боловсрол эзэмшиж, орлого олж нийгмийн амьдралд идэвхтэй оролцох болжээ.

Оффиссын ажил эрхэлдэг эмэгтэйчүүд 2003 онд нийт ажиллаж буй эмэгтэйчүүдийн 43 хувийг эзэлдэг байсан бол 2010 онд 47 хувь болж өссөн ба 2020 онд хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн талаас дээш хувь нь оффисст ажиллах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл Хятад эмэгтэйчүүд улам бүр бие даасан, өндөр орлоготой нэгэн төрлийн хэрэглэгчдийн төлөөллийг бий болгож байна. Эдгээр өндөр орлоготой эмэгтэйчүүд өрхийн худалдан авалтын шийдвэр, ялангуяа өндөр үнийн дүнтэй худалдан авалтын шийдвэр гаргахад эрчүүдтэй эн зэрэгцээ байр суурь эзлэх юм.

5.4 Борлуулалтын суваг

Хувцасны борлуулалтын сувгуудад их дэлгүүрүүд, нэрийн барааны дэлгүүр, зах худалдааны байгууллага хамаардаг байсан бол сүүлийн жилүүдэд агуулахын худалдааны маягийн худалдааны төв, супермаркет болон сүлжээ

дэлгүүрүүд, төрөлжсөн хувцасны зах, ТВ болон онлайн захиалгын худалдаа багтдаг болсон.

Хонконгийн зах зээлийн судалгааны Эйч Кей Ти Ди Си байгууллагын судалгаагаар Хятадын худалдан авагчдын дийлэнх буюу 62 хувь нь хувцсаа их дэлгүүрээс худалдан авдаг гэсэн дүн гарчээ.

Ялангуяа дундаж болон өндөр орлоготой иргэд брэнд хувцсыг тав тухтай дэлгүүрийн орчинд худалдан авахыг илүүчлэн үздэг хэвээр байна. Хятадад хувцас худалддаг борлуулалтын түгээмэл сувгууд дараах байдалтай байна. Үүнд:

1. Төрөлжсөн хувцасны зах: Хятадад хувцасны борлуулалтын сүлжээнд төрөлжсөн зах чухал байр эзэлдэг. Ийм төрлийн хувцасны төрөлжсөн захуудаас дурдвал:*Хятадын өмнөд бүс:* Гуанжуд Байма болон Шадонг зэрэг төрөлжсөн хувцасны захууд байршдаг. Энэхүү бизнесийн дүүргүүдэд 10 гаруй хувцасны томоохон агуулах байршдаг. Түүнчлэн Гуандонг-ийн Хүмэн дүүрэгт мөн хувцасны томоохон захууд ажилдаг. Үүнд Фүмин худалдааны төв болон Хуанхэ Фашин Сити гэх мэт хувцас худалдааны захууд байршдаг.

Хятадын зүүн бүс: Шанхай, Жиансу болон Зэйжанг хотуудад хувцасны төрөлжсөн бөөний худалдааны төвүүд байрладаг. Үүнд: Шанхай хотод Кипү Лү хувцасны бөөний худалдааны зах, Жиансу хотод Худалдаачдын зах, Пуяанд ноосон цамц, хувцасны зах, Хайнинг хотод савхин хувцасны бөөний худалдааны захууд байршдаг.

Хятадын хойд бүс: Хятадын хувцасны төрөлжсөн захууд голдуу Бээжинг, Тианжин, Хэбэ болон Шандонг хотуудаар тархсан. Үүнд Бээжин хотын Мушиан худалдааны дүүрэг болон Шандонг хотын хувцасны бөөний худалдааны төв, Жинан хотын Луоко хувцасны бөөний худалдааны захууд байршдаг.

2. Төрөлжсөн дэлгүүр: Брэнд хувцас худалдах гол суваг бол төрөлжсөн дэлгүүр юм. Хятадын үйлчлүүлэгчид өндөр үнэтэй тансаг хэрэглээний хувцас, барааг өөрийн биеэр дэлгүүр дээр очин худалдан авч үйлчлүүлэх хандлага

түлхүү байна. Дэлхийн нэр хүнд бүхий гадаадын болон дотоодын зах зээлд өөрийн брэндийг таниулах хүсэлтэй компаниуд төрөлжсөн нэрийн барааны дэлгүүр байгуулах хандлагатай байна.

3. Супермаркетад хувцас худалдаалах: Энэ борлуулалтын сувгийг хэрэглэдэг компаниуд төдийлөн өөрийн брэнд бүтээгдэхүүнийг гаргаж олон танигдаагүй байдаг хэдий ч харьцангуй хямд үнээр өргөн хэрэглээний хувцсыг олонд түгээх худалдаалах сонирхолтой байдаг.

4. Их дэлгүүрүүд дотор өөрийн нэрийн барааны дэлгүүр, тасгийг ажиллуулах: Их дэлгүүрүүдээр явж нэгэн зэрэг олон төрлийн бараа үйлчилгээг хүртэх сонирхолтой хэрэглэгчдийг татах зорилгоор их дэлгүүрүүд дотор байрших тасаг, дэлгүүрүүдээр дамжуулан хувцас зардаг. Гэхдээ тухайн их дэлгүүрийн ерөнхий хэв маяг, хандлагад тодорхой хэмжээгээр захирагдах болдог тул үнэтэй брэндүүд төдийлөн их дэлгүүрт байршихыг бус харин өөрийн хэв шинжийг агуулсан нэрийн барааны дэлгүүрүүдээр бүтээгдэхүүнээ түгээхийг илүүд үздэг.

5. Цахим худалдааны суваг: Хятадын статистикийн хорооны мэдээгээр нийт борлуулагдаж буй өргөн хэрэглээний барааны 15.5% нь цахим худалдааны сувгаар дамжсан байдаг. Борлуулалтын цахим сувгууд:

6. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, СТАНДАРТАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хятад улсад бүтээгдэхүүн нийлүүлэх сонирхолтой компаниуд Хятадын чанарын хяналтаас тогтоосон стандарттай танилцах, тэдгээрийн дагуу үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Хятадын стандартчиллын хуулийн хүрээнд мөрдөгдөж буй стандарт нь 4 ерөнхий бүлэгт хуваагдана. Үүнд:

1. Үндэсний стандарт
2. Салбарын стандарт
3. Орон нутгийн стандарт
4. Үйлдвэрийн стандарт

1. Үндэсний стандарт

Хятад улс даяар даган мөрдөгддөг GB үсгээр эхэлсэн стандартууд энэ бүлэгт хамаарна. Эдгээр стандартуудын 15% нь заавал дагаж мөрдөх стандарт байдаг бол зарим нь зөвлөмж маягтай батлагдсан байдаг. Эдгээр стандартыг 3 үндсэн хэсэгт хуваан эхний үсгүүдээр таних боломжтой. Үүнд:

Хүснэгт 9: Үндэсний стандартын ангилал

Код	Утга
GB	Заавал мөрдөх стандарт
GB/T	Сайн дурын үндсэн дээр мөрдөх стандарт
GB/Z	Үндэсний стандартыг мөрдөх зааварчилгаа

2. Салбарын стандарт

Салбарын буюу үйлдвэрийн стандарт гэдэгт үндэсний стандартад тусгагдаагүй ч улсын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх техникийн шаардлага, стандартыг хамруулдаг. Энэ нь үндэсний стандарттай төстэй стандартууд юм. Гэхдээ эдгээрийг тухайн салбар хариуцсан яам, байгууллагаас гаргадаг ба дотроо мөн заавал мөрдөх болон сайн дурын гэсэн бүлэгт хуваагддаг. Салбар салбарын код, үсгүүд ялгаатай байдаг.

3. Орон нутгийн стандарт

Улсын хэмжээнд болон салбарын хэмжээнд зохицуулагдаагүй ч тухайн орон нутгийн хэмжээнд хангах шаардлагатай гэсэн стандартууд байдаг. Ерөнхийдөө шинэ стандартыг ямарваа нэг орон нутгийн хэмжээнд дагаж

мөрдүүлэн хэрэгжилтийн байдлыг харгалзан улсын хэмжээнд нэвтрүүлэх эсэхээ шийддэг жишигтэй. Өөрөөр хэлбэл туршилтын зорилгоор тухайн орон нутгийн хэмжээнд нэвтрүүлсэн стандартууд байх нь түгээмэл. Эдгээрийг мөн кодын эхний үсгүүдээр таних боломжтой буюу DB+орон нутгийн код байвал тухайн орон нутгийн хэмжээнд заавал мөрдөх стандарт, DB+орон нутгийн код/Т байвал тухайн орон нутгийн хэмжээнд сайн дураар мөрдөх стандартууд хамаарна.

4.Үйлдвэрийн стандарт

Хэрэв үндэсний, салбарын болон орон нутгийн стандартаар зохицуулагддаггүй ч тухайн байгууллага, үйлдвэрийн хувьд дагаж мөрдөх шаардлагатай байвал энэ төрлийн стандартаар зохицуулагдана. Энэ төрлийн стандартууд Q+үйлдвэрлэлийн код гэсэн тэмдэглэгээтэй ба байгууллагын чанарын хяналтын системийн хэсэг болдог.

Хятадын стандартчиллын үндэсний хяналтын систем дараах бүтэцтэй. Үүнд:

1. БНХАУ-ын Төрийн зөвлөлийн харьяа Чанарын хяналт, хорио цээрийн ерөнхий газар (AQSIQ)

Тус байгууллага нь чанарын хяналт, хэмжилт, экспорт, импортын барааны хяналт шалгалт, эрүүл ахуй, хорио цээрийн хяналт баталгаажуулалт, стандартчиллын асуудал хариуцсан байгууллага юм.

2. Хятадын Нэвтрэх-Гарах хяналтын хорио цээрийн товчоо (CIQ)

Энэ нь Хятадын хилээр нэвтрэх болон гарах бараа бүтээгдэхүүний хяналт, хорио цээрийн асуудлыг хариуцдаг. Тус байгууллага нь хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл, чингэлэг, шуудан болон ачаа барааны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хянан бараа бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулдаг.

3. Чанар, технологийн хяналтын газар

Тухайн орон нутгийн Чанар, технологийн хяналтын газар нь өөрийн орон нутагтаа борлуулагдаж буй бараа бүтээгдэхүүнээс дээж авах, шинжлэх, хянан шалгах зэрэг ажлыг гүйцэтгэдэг.

4. БНХАУ-ын Үйлдвэр, худалдааны удирдлагын газар болон орон нутгийн үйлдвэр худалдааны удирдлагын газар

Эдгээр байгууллагуудын үндсэн үүрэг нь худалдаанд эргэлдэж буй бараа бүтээгдэхүүний аюулгүй байдал, чанарт хяналт тавих, бүртгэх болон худалдааны тэмдгийг зохицуулах, хууль журам мөрдүүлэх, шаардлагатай тохиолдолд торгууль тавих, үйл ажиллагааг зогсоох зэрэг болно.

Одоогоор хувцас үйлдвэрлэлтэй холбоотой 60 орчим үйлдвэрийн стандарт дагаж мөрдөгддөг. Үүнээс даавуунд хээ гаргах болох будахтай холбоотой 9, ноосон даавуу үйлдвэрлэхтэй холбоотой 15, ор хөнжлийн даавуу үйлдвэрлэхтэй холбоотой 15, торгоны үйлдвэрлэлтэй холбоотой 4, нэхмэлийн 11, нэхмэлийн машин тоног төхөөрөмжтэй холбоотой 10 орчим стандарт байна.

Сүлжмэл эдлэлийн салбарт дагаж мөрдөх 21 стандартыг нэгтгэвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 10: Сүлжмэл эдлэлийн салбарт дагаж мөрдөх стандартууд

Д.д	Код	Он	Стандартын нэр
1	FZ/T73009	2009	Ноолууран хувцас
2	FZ/T71006	2009	Ноолууран нэхмэлийн утас
3	GB/T18267	2000	Ноолуур
4	Q/NLW009	2009	Түүхий эд худалдан авахад баримтлах техникийн шалгуур болон хяналтын зарчим
5	GB/T14575	2009	Даавууны өнгөний тогтцыг шалгах
6	GB/T3922	1995	Даавууны үнэр, түүний тогтцыг шалгах
7	GB/T5713	1997	Даавууны өнгөний тогтоц болон угаалга даах чадвар
8	GB/T251	2008	Сорьцын саар будгаар толбо тогтолтыг шалгах арга
9	FZ/T20002	1991	Ноосон даавууны тослогийн хэмжээг тодорхойлох
10	Q/NLW008	2008	Сайн чанарын ноолууран даавууг ялгах
11	FZ/T24011	2010	Ноолууран сүлжмэл ороолт, хүзүүний алчуур
12	Q/NLW018	2008	Ноолуурын орц багатай цамц
13	GB/T3923.1	1997	Сүлжмэл эдлэлийн сунах чанар
14	GB/T4802.1	2008	Сүлжмэл даавуун бөөстөх чанар
15	GB9994	2008	Даавуун эдлэлийн чийг таталт
16	GB/T8691	1988	Индүүдлэгийн дараах даавуун эдлэл хэлбэр дүрсээ хадгалах чанар
17	FZ/T61001	2006	Цэвэр болон хагас ноосон хөнжил
18	FZ/T24009	2010	Ноолууран даавуу

19	FZ/T80002	2008	Хувцасны тэмдэг, сав баглаа боодол, тээвэрлэлт, хадгалалт
20	SN/T1932.5	2008	Экспортын хувцас, даавууг шалгах аргачлал
21	GB18401	2010	Сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлд баримтлах аюулгүйн ерөнхий зааварчилгаа

Үнээс жишээ болгон тайлбарлавал: **GB18401** нь 2010 онд батлагдсан сүлжмэл бүтээгдэхүүний техникийн аюулгүй байдлын талаарх Хятадын үндэсний хэмжээнд заавал мөрдөх стандарт юм. Энэхүү стандартыг нь дотоодын үйлдвэрлэгч нар болон сүлжмэл бүтээгдэхүүн Хятадад импортолж буй аж ахуйн нэгжүүд мөрдөх үүрэгтэй ба ийм төрлийн бүтээгдэхүүний үндэсний чанарын хяналтын системийн суурь болдог. Энэхүү стандартын техникийн шаардлагыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 11: GB18401 сүлжмэл бүтээгдэхүүний техникийн аюулгүй байдлын шаардлага

Шалгуур	Шинжлэх арга	Бүлэг А	Бүлэг В	Бүлэг С
Формальдегид агууламж (mg/kg) ≤	GB/T 2912.1	20	75	300
PH	GB/T 7573	4.0-7.5	4.0-8.5	4.0-9.0
Өнгө хадгалалтын байдал				
Ус тэсвэрлэх чанар (өнгө алдах болон толбо тогтох)	GB/T 5713	3-4	3	3
Хүчиллэг хөлс тэсвэрлэх чанар (өнгө алдах болон толбо тогтох)	GB/T 3922	3-4	3	3
Шүлтлэг хөлс тэсвэрлэх чанар (өнгө алдах болон толбо тогтох)	GB/T 3922	3-4	3	3
Үрэлтээс цахилгаанжих байдал	GB/T 3920	4	3	3
Шүлс тэсвэрлэх чанар (өнгө алдах болон толбо тогтох)	GB/T 8886	4	-	-
Хурц үнэр	GB 184016.7	Үнэргүй байх		
Хорт хавдар үүсгэгч, үнэртэй будаг найрлагад орсон эсэх	GB/T 17592 GB/T 23344	Хориглох		

GB/T18267 стандартыг үндэсний хэмжээнд баримталдаг, доорх үзүүлэлтүүдийг хангахыг зөвлөсөн байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл энэ нь заавал мөрдөх стандарт биш хэдий ч ноолуур боловсруулахдаа удирдамж болгох стандарт юм. Үүнд:

Хүснэгт 12: GB/T18267 стандартын шаардлага

Стандарт	Өнгө	Урт (мм)	Ширхэг (мм)	Хаягдал (%)	Бусад агууламж (%)	Ноолуурын агууламж (%)
Ноолуур бэлдэх	Цагаан	34-36	≤15.9	≤0.13	≤0.25	≥95

Эдгээр стандартуудыг тус бүрчлэн үнэлсэн байдаг холбогдох байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлэл худалдан авах боломжтой.

7. ЗАСГИЙН ГАЗРААС НООС, НООЛУУРЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ ХӨНГӨЛӨЛТ, ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА

Хятад улс 1995 оноос хойш дэлхийд даавуу, сүлжмэл эдлэл, хувцасны экспортоор тэргүүлэх болсон. Энэхүү амжилтад хүрэхэд Хятадын Засгийн газар чухал үүрэг гүйцэтгэсэн ба 1990-ээд оны сүүл үеэс эхлэн 2006 оны хооронд Засгийн газрын шууд дэмжлэгтэйгээр нийт 110 сая даавуу ээрэгч машин, 280,000 ноос ээрэгч машиныг шинэчлэн сольсон. Үүнд Засгийн газраас 3.1 тэрбум юанийн дэмжлэгийг үйлдвэрүүдэд татаас болон татварын хөнгөлөлт, буцаан олголт хэлбэрээр олгосон байдаг. Энэ үеэс эхлэн Япон, Герман, Итали, АНУ –аас хувцас үйлдвэрлэлийн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж эхэлсэн ба 2000 оны үед салбарын хэмжээнд нийт 18.9 тэрбум ам.долларын хөрөнгийг зарцуулсан гэсэн тооцоо байдаг.

Хятадын Засгийн газраас экспортыг дэмжих болон импортыг орлуулах зорилго бүхий дотоодын үйлдвэрүүд аж ахуйн нэгжүүдэд олгож буй татаас, дэмжлэг, татварын хөнгөлөлтүүд нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд худалдааны чөлөөт өрсөлдөөнд саад учруулж буй талаар АНУ, Мексик болон Европын орнууд гомдол гаргадаг.

Үүнд Хятадын Засгийн газраас 2006 онд Дэлхийн худалдааны байгууллагад өөрийн орны үйлдвэр аж ахуйн нэгж болон эдийн засгийн бүхий л салбарт үзүүлсэн 78 төрлийн дэмжлэг, татаас татварын хөнгөлөлтийн талаарх дэлгэрэнгүй тайланг гаргаж өгсөн байдаг. Энэхүү тайлангаас харахад ноос, ноолуурын салбарт ажиллаж буй дотоодын үйлдвэрүүдэд маш олон төрлийн татаас, татварын хөнгөлөлтөд хамрагддаг байв.

7.1 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт үзүүлж буй дэмжлэг туслалцаа

БНХАУ-ын Засгийн газраас ноос, ноолуур боловсруулах салбарыг дэмжих нэг хэлбэр нь бүтээгдэхүүнээ гадаадын зах зээлд гаргахад татварын хөнгөлөлт, буцаан олголт хийх замаар хэрэгждэг байсан нь сүүлийн жилүүдэд өөрчлөгдөх хандлагатай байна.

Ноосонд ногдуулах татварын буцаан олголт 13%, байснаас 2004 оноос хойш тэглэсэн байна. Харин ноолууран утсанд олгож байсан татварын буцаан олголтын хэмжээ 15%-иас буурч 2004 онд 13%, цаашид 8% болжээ.

Экспортод гаргадаг ноолууран хувцас, эцсийн бүтээгдэхүүний экспортын татварын хувь 17% байсан бол 11% болж буурчээ. Хятадын ноос ноолуурын салбарт олон жижиг дунд боловсруулах үйлдвэр байдаг ба татварын буцаан олголтын урамшууллаар багахан хэмжээний ашигтай ажилдаг байсан эдгээр жижиг үйлдвэрүүд цаашид зах зээлээс гарах магадлал өндөр байна.

Олон тооны жижиг үйлдвэрүүд ноос, ноолууран бүтээгдэхүүний зах зээлд үнээр голчлон өрсөлдсөнөөр бүтээгдэхүүний нэр хүнд буурч, Хятадын ноос, ноолууран бүтээгдэхүүний чанар, үнэлэмж, нэр хүндэд сөргөөр нөлөөлж буй тухай шүүмжлэл судалгаа шинжилгээний нийтлэлүүд нэлээд гарсан байна.

Хятадын ноос, ноолуурын салбарт баримталж буй бодлого, шийдвэрүүдийг жагсаавал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 13: Хятадын ноос, ноолуурын салбарт баримталж буй бодлого шийдвэрүүдийн жагсаалт

	Бодлого, шийдвэр	он	Хариуцах байгууллага
1	Нэхмэлийн үйлдвэрийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах, шинэ технологи нэвтрүүлэх тухай шийдвэр	2006	Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо Сангийн яам ШУ, технологийн яам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Худалдааны яам
2	Нэхмэлийн үйлдвэрийн "Арваннэгдүгээр таван жилийн төлөвлөгөө"-нд туссан хөгжлийн хөтөлбөр	2006	Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо
3	“Дэлхийд гарах” бодлогын хүрээнд нэхмэлийн үйлдвэрлэгчдийг гадаад худалдааны бодлогоор дэмжих захирамж	2006	Сангийн яам Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо Худалдааны яам
4	Сүлжмэл болон бэлэн хувцас зэрэг бүтээгдэхүүнд ноогдох экспортын татварын хэмжээг тогтоох тухай шийдвэр	2008	Сангийн яам Татварын алба
5	Сүлжмэл эдлэлийн салбарыг дэмжих, бэхжүүлэх төлөвлөгөө	2009	Төрийн зөвлөл
6	"Сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэлээр хүчирхэг үндэстэн болох төлөвлөгөө (2011-2020)"	2011	Хятадын сүлжмэлийн холбоо
7	"Сүлжмэлийн үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөө (2016-2020)"	2016	Инженерийн зөвлөл

Хятадын Засгийн газраас 2006 онд баталсан Хятадын даавуу, нэхмэл эдлэлийн үйлдвэрийг дэмжин “Дэлхийд гарах” бодлогын хүрээнд Сангийн яам, Эдийн засгийн хөгжил, шинэчлэлийн хороо, Худалдааны яамнаас салбарын хөгжлийг дэмжих төсөв батлан томоохон санхүүжилтүүдийг хийсээр ирсэн. Дээрх сангийн хөрөнгийг дараах байдлаар зарцуулсан байна. Үүнд:

- Гадаад худалдааг дэмжих зорилгоор даавуу, нэхмэлийн салбарт шинэ технологи нэвтрүүлэх, үйлдвэрийн бүтцийг сайжруулах:
    - Технологийн дэвшил, үндсэн техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэчлэх, брэнд бий болгох, олонд танилцуулах төслүүдэд нэг удаагийн санхүүжилт олгох,

- Дэлхийд танигдсан бараа, бүтээгдэхүүн гаргах хөтөлбөрийн хүрээнд даавуу, нэхмэлийн үйлдвэрүүдэд гадаад улсуудад байгуулах үйлдвэр, салбарыг дэмжих
    - Хятадын даавуу, нэхмэлийн үйлдвэрүүдийг Дэлхийнд танигдсан бараа бүтээгдэхүүн гаргах хөтөлбөрийн хүрээнд R&D, зөвлөх үйлчилгээ, оюуны өмчийг хамгаалах чиглэлээр гаргасан зардлыг Засгийн газраас нөхөн олгох,
    - Хятадын даавуу, нэхмэлийн үйлдвэрлэгчдийн гадаад орны зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх борлуулалтын суваг байгуулах чиглэлээр гаргасан зардлыг нөхөн олгох,
    - Хятадын тэргүүлэгч даавуу болон нэхмэлийн үйлдвэрүүдэд Дэлхийд танигдсан бараа бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагааг дэмжих,

Энэхүү хөтөлбөрт нийт 1.35 тэрбум юанийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн ба үүнээс 560 сая юанийг техник, технологийг сайжруулах төсөл хөтөлбөрт, харин 800 сая юанийг дэлхийд танигдсан бараа бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Энэхүү санхүүжилтийн зарим хэсгийг төв засгийн газар буюу Сангийн яам болон Худалдааны яамнаас олгосон бол зарим хэсгийг орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан даавуу, нэхмэл эдлэлийн үйлдвэрлэгчдэд олгосон байна. Дээрх татаасыг олгосон нөхцөлийг хураангуйлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 14: “Дэлхийд гарах” бодлогын хүрээнд олгосон татаас

Татаасын зориулалт	Татаасын хэмжээ	Хүлээн авагч
Гадаад оронд даавуу, нэхмэлийн үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх	2 сая юань хүртэлх санхүүжилтийг тусламж болгон олгох	Төсөл хэрэгжүүлэгч
Гадаад оронд хэрэгжүүлж буй төслийн даатгалын зардалд дэмжлэг үзүүлэх	Даатгалын зардлын 50 хүртэлх хувийн санхүүжилтийг нөхөн олгох	Төсөл хэрэгжүүлэгч

Гадаад оронд үйлдвэр байгуулахтай холбоотой газар худалдан авах болон түрээслэх зардалд дэмжлэг үзүүлэх	1 сая юань хүртэлх хэмжээний тусламж олгох	Компаниуд
Гадаад оронд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төслийн даатгалын зардлыг хөнгөлөх	Даатгалын зардлын 50 хүртэлх хувийн санхүүжилтийг нөхөн олгох	Компаниуд
Гадаад улсад бараа материал худалдан авах, загвар зохион бүтээгч хөлслөн ажиллуулах болон R&D үйл ажиллагаанд зориулан байр түрээслэх зэрэг зардалд дэмжлэг үзүүлэх	500,000 юань хүртэлх тусламж үзүүлэх	Компаниуд
Гадаад оронд барааны тэмдэг бүртгүүлэх, сертификат авахад дэмжлэг үзүүлэх	Гарсан зардлын 50 хувийг нөхөн олгох	Компаниуд
Гадаад оронд барааны тэмдэг, оюуны өмчтэй холбоотой гарсан арбитрын болон шүүхийн зардалд дэмжлэг үзүүлэх	Нийт зардлын 50 хувийг нөхөн олгох (нийт нөхөн олговор 500,000 юаниас хэтрэхгүй байх)	Компаниуд
Гадаад улсад байгуулсан бутик дэлгүүрүүдийн түрээсийн болон дотоод засал, чимэглэлийн зардалд дэмжлэг үзүүлэх	200,000 юань хүртэлх хэмжээний тусламж олгох	Компаниуд
Гадаад улсад байгуулсан борлуулалтын дараах үйлчилгээ, логистикийн төвийн оффис болон агуулахын түрээсийн зардалд дэмжлэг үзүүлэх	100,000 хүртэл юанийн тусламж үзүүлэх	Компаниуд
Гадаад орнуудад борлуулалтын дараах үйлчилгээний мэдээлэл, удирдлагын системийн программ худалдаж авах зардлыг дэмжих	Нийт гарсан зардлын 50 хувийг нөхөн олгох	Компаниуд
Гадаад орнуудад байгуулсан худалдаа, маркетингийн салбаруудын даатгалын зардалд дэмжлэг үзүүлэх	Даатгалын зардлын 50 хувийг нөхөн олгох	Компаниуд

Гадаад орнуудад хийсэн үйлдвэр, үйлчилгээтэй холбоотой хийгдсэн мэдээллийн сан, вэбсайт хийхэд гарах зардалд дэмжлэг үзүүлэх	Зардлын 50 хувийг нөхөн олгох	Компаниуд болон тэдгээрийн гэрээт газрууд
Хөрөнгө оруулалтын үзэсгэлэн яармагт зориулсан орчуулга, зар сурталчилгаа, байр талбай түрээслэх зардалд дэмжлэг үзүүлэх	200,000 хүртэл юанийн тусламж үзүүлэх	Компаниуд болон тэдгээрийн гэрээт газрууд

Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр болон Даавуу нэхмэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдааг дэмжих сан

Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр болон даавуу нэхмэлийн үйлдвэрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, экспортод гаргах бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилго бүхий тусгай санг төв засгийн газраас байгуулсан. Үүнд, Сангийн яам болон Худалдааны яамнаас нэхмэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниуд R&D төслүүд хэрэгжүүлэх бол, орон нутгийн болон улсын худалдан авалтад сүүлийн 3 жилд оролцсон болон өөртөө 500-аас дээш гишүүнчлэл бүхий үйлдвэрийн холбоод нь дээрх сангаас санхүүжилт авах эрхтэй. Голчлон үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэ технологи нэвтрүүлэх, бүтээгдэхүүний загвар, чанарын хяналтыг сайжруулахад чиглэсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн. Энэ чиглэлээр хэрэгжсэн төслүүдэд 2 сая юань хүртэлх буцалтгүй тусламжийг Хятадын Засгийн газраас олгожээ.

Брэнд хөгжүүлэхтэй холбоотой санхүүгийн дэмжлэг

Хятад Улсын Засгийн газраас Хятад гаралтай дэлхий хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахад ихээхэн анхаарч дэмжлэг үзүүлдэг. Энэ ажлын хүрээнд “Брэнд байгуулах 10000 алхам”, “Нэхмэлийн салбарын шилдэг 50 брэнд”, “Худалдааны яамнаас дэмжлэг үзүүлэх шилдэг брэндүүд” гэх зэрэгтөрөл бүрийн арга хэмжээг тогтмол зохион байгуулан дотоодын үйлдвэрлэгчдээ брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэхийг урамшуулан дэмжсээр ирсэн. Үүний хүрээнд дараах үйл ажиллагааг санхүүжүүлсээр ирсэн байна. Үүнд:

- Компаниудыг брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- Компаниудыг үндэсний болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх
- Брэнд сурталчлах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- Брэнд хөгжүүлэхтэй холбоотой олон улсын сургалт, семинар, зөвлөхийн үйлчилгээг хэрэгжүүлэх
- Брэнд хөгжүүлэхтэй холбоотой Засгийн газраас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээг тодорхойлон санхүүжүүлэх

Брэнд хөгжүүлэхтэй холбоотой Засгийн газраас үзүүлэх буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, арга хэмжээ тус бүр 200,000 юань хүртэл эсвэл төсөл хөтөлбөрийн зардлын 50 хүртэлх хувийн санхүүжилтийг, хэрэв тухайн арга хэмжээг орон нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулж хэрэгжүүлсэн тохиолдолд 100 хувийн санхүүжилтийг Засгийн газраас хийж ирсэн байна.

Засгийн газраас татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дэмжлэг үзүүлэх

Даавуу болон нэхмэлийн үйлдвэрлэлийг дэмжихэд зориулан Засгийн газраас тус салбарт үйл ажиллаа явуулж буй компаниудад татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хэлбэрээр дэмжлэг үзүүлж ирсэн. Үүнд, орлогын татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, импортын татвар болон НӨАТ-ийн нөхөн олголт багтана.

Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд бараа бүтээгдэхүүний сурталчилгааны зардал нь нийт орлогын 8 хувь болон түүнээс бага үнийн дүнтэй тохиолдолд сурталчилгааны зардалд татвар ногдуулахгүй ба хэрэв 8 хувиас илүү тохиолдолд татвар ноогдох хэсгээ дараа жилд шилжүүлэх гэх зэргээр хүссэн хугацаагаар хойшлуулах боломжтой. Энэхүү татварын хөнгөлөлтийг тухайн үйлдвэр, компанийн эзэмшлийн хэлбэрээс үл хамааруулан хувийн болон улсын компаниудад адилаар тогтоож өгсөн байна.

Түүнчлэн тухайн байгууллага R&D зардлаа өмнөх жилээс 10 хувиар өсгөсөн тохиолдолд нийт зардлын 50 хувийг татвар ногдуулахгүйгээр чөлөөлдөг жишиг хэрэгжсэн.

Харин 2007 оноос Төрийн зөвлөлөөс гаргасан Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг сайжруулах зааварчилгааны хүрээнд Сангийн яам болон Эдийн засаг, шинэчлэлийн улсын хороо, Гаалийн ерөнхий газрын хамтын ажиллагааны хүрээнд дотоодод үйлдвэрлэх боломжгүй эсвэл чухал хэрэгцээ бүхий түүхий эд болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сэлбэгийг хилээр нэвтрүүлэх үед гаалийн болон НӨАТ-аас бүрэн чөлөөлсөөр иржээ.

Түүнчлэн дотоодын болон гаднын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд шинэ дэвшилтэт технологи үйлдвэртээ нэвтрүүлбэл орлогын татварыг тухайн үед тогтоосон хувь хэмжээгээр хөнгөлдөг байна.

Орон нутгийн захиргаанаас өөрийн нутаг дэвсгэрт байрлах үйлдвэрт үзүүлэх дэмжлэг

Төв засгийн газрын дээр дурдсан урамшуулал, татаасаас гадна тухайн орон нутгийн байгууллага өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй үйлдвэр, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь элбэг тохиолдол юм.

Зарим мужид тухайн компанийн экспортод гаргасан бүтээгдэхүүний үнийн дүнгийн хэмжээнээс мөнгөн урамшуулал олгодог бол Фузянь мужийн Шиши хотын захиргаанаас тухайн орон нутгийн үйлдвэр чанарын хяналтын гэрчилгээ авах, орон нутаг, улсын хэмжээнд нэр хүндтэй шагнал авсан тохиолдолд 500,000 хүртэл юанийн мөнгөн шагналыг олгодог жишиг тогтоосон байна.

Зээлийн хүүг нөхөн олгох урамшуулал

Ноос, ноолуурын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд техник, технологио сайжруулан шинэ тоног төхөөрөмж худалдан авах зорилгоор авсан зээлийн хүүгийн хувь хэмжээгээр тухайн орон нутгийн захиргаанаас нөхөн олговор олгох тохиолдлууд байдаг. Жишээлбэл Фузянь мужийн Зонгшан хотын захиргаанаас өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нэхмэл эдлэлийн үйлдвэрүүд технологио сайжруулах зорилгоор авсан зээлийн хүүгийн 3 сая юань хүртэлх эсвэл нийт төлбөрийн 30-40 хувийг орон нутгийн төсвөөс татаас болгон нөхөн санхүүжүүлэх зохицуулалттай ажиллаж ирсэн.

Орон нутгийн даавуу, нэхмэл эдлэлийн үйлдвэрийн паркаас үзүүлдэг дэмжлэг

Тухайн орон нутгийн эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн захиргаанаас үйлдвэрлэлийн паркийг байгуулан дотоодын болон гаднын хөрөнгө оруулалтай үйлдвэрүүдийг татахыг эрмэлздэг. Жишээлбэл Жилин мужийн Лиаюань хотод байршдаг Үйлдвэрийн паркийн урамшуулал нь:

- Орон нутгийн орлогын татварыг эхний 5 жилийн хугацаанд буцаан олгох, жилийн НӨАТ-ын хэмжээ нь 1 сая юань, худалдааны татварын хэмжээ нь 500,000 юань давсан тохиолдолд эдгээр татварын 20 хүртэл хувийг буцаан олгодог.
- Хэрэв хөрөнгө оруулалтын хэмжээ нь 10 сая юань болон түүнээс дээш, татварын нийн хэмжээ нь 1 сая юань болон түүнээс дээш байх тохиолдолд газрын түрээсийн төлбөрөөс 20 жилийн хугацаагаар бүрэн чөлөөлдөг.

Төвийн болон орон нутгийн захиргааны байгууллагын дээр дурдсан тусламж, татаас, хөнгөлөлт чөлөөлт нь үйлдвэрийн хөгжилд асар том түлхэц өгснөөр ирсэн нь Хятадын ноос, ноолуурын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй үйлдвэрүүд хэрхэн өсөн хөгжиж дэлхийн хамгийн сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмж, технологийг үйлдвэртээ нэвтрүүлж байна.

Хятадын ноолуурын салбарын хамгийн том төлөөлөгч болох Өвөр Монголын Ордос ресурс ХК-ийн 1999-2006 оны хооронд хүлээн авсан санхүүгийн дэмжлэгийн хэмжээг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 15: Өвөр Монголын Ордос ресурс ХК-ийн 1999-2006 онд авсан санхүүгийн дэмжлэг

/юань/

Он	Татаас	Компанийн орлого	Орлогод эзлэх татаасын хувь
1999	608,337	1,479,731,279	0.041
2000		1,821,818,156	
2001	50,620	2,427,947,819	0.002
2002	10,093	2,215,020,454	0.000
2003	317,057	2,917,197,868	0.011
2004	4,185,549	3,097,504,326	0.135
2005	6,883,030	2,939,924,055	0.234
2006	18,611,428	4,002,706,259	0.465
Нийт	30,666,114	20,901,850,216	0.147

Эх сурвалж: Trade lawyers advisory group

Хятадын Засгийн газраас ноос, ноолуурын салбарт томоохон байр суурь эзэлдэг Өвөр Монголын Ордос ресурс, Дийр Кинг гэх зэрэг ноос, ноолуурын салбарын бүх шат дамжлагад үйл ажиллагаа эрхлэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг томоохон үйлдвэр компаниудаа тууштай дэмжсээр ирсэн. Үүнд хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд эдгээр компаниудын техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, дотоодын зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээлд гарах боломжийг хангах зорилго бүхий төрөл бүрийн арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлсээр ирсэн.

7.2 Малын үүлдэр, ноос, ноолуурын түүхий эдийн чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор хийгдсэн Засгийн газрын бодлого, дэмжлэг

Хятадын Засгийн газраас ноос, ноолуурын салбарын хөгжлийг үе шаттайгаар алсын хараатай бодлогоор дэмжиж иржээ. Үүний үр дүнд сүүлийн жилүүдэд Хятадын ноос, ноолуурын хонь ямааны үүлдэр сайжирч чанар, гарц нь нэмэгдсээр байна.

Ноос, ноолуурын чанар болон нэг малаас гарах түүхий эдийн гарцыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ малын тоо толгойг зохистой түвшинд барих, байгаль экологийн тэнцвэр хадгалах зорилго бүхий малчдад зориулсан урамшууллын механизмыг ажиллуулж эхэлсэн. Үүний ачаар Хятадын ноолуурын ямааны үүлдэр эрс сайжирч нэг ямаанаас гарах ноолуурын гарц өсчээ.

Хятадын Засгийн газраас сайн үүлдрийн ноолуурын ухна ямааны тоогоор олгох урамшууллын системийг 2009 оноос нэвтрүүлсэн. Хэрэв малчин сайн үүлдрийн ухна худалдан авах бол Засгийн газраас дэмжлэг болгон 800 юань тэтгэлэг болгон өгч байна.

Түүнчлэн бэлчээрийн ашиглалт, экосистемийг хадгалах зорилго бүхий бэлчээрийг хашин өнжүүлэх, түүний хүрээнд малчдад нөхөн урамшуулал олгох болсон. Малчдад нийт ноос, ноолуурын гарцын хэмжээнээс хамааруулан орон нутгийн захиргаагаар дамжуулан урамшуулал олгохын зэрэгцээ тухайн жилд малын үүлдэр сайжруулах үржүүлгийн техник худалдан авах бол түүнийхээ зардлын тодорхой хувийг засгийн газраас нөхөн олголтоор авдаг байна.

Хятадын Засгийн газраас сүргийн бүтцээ сайжруулах зорилгоор сайн үүлдрийн хуц худалдан авсан малчдад мөн 2009 оноос урамшуулал олгодог болсон.

Сүүлийн жилүүдэд Хятадын дотоодын зах зээлд ноолуурын үнэ буурсантай холбоотой малын сүргийн бүтцэд өөрчлөлт орж малчид ноос, махны үүлдрийн хонь хариулахыг илүүд үзэх хандлага гарсан. Үүнд Хятадын хөдөө аж, ахуйн эрдэм шинжилгээ, судалгааны нийтлэлд эрдэмтэн судлаачид ноолуурын үнийг тогтмол түвшинд барих, ноолуурын үнэ хүлээгдэж байснаас доогуур түвшинд тогтвол түүний зөрүүг татаас болгон олгох замаар ноолуурын салбарт гаргасан амжилтаа цаашид хадгалахыг зөвлөсөн байна.
Хятадын Засгийн газраас хамгийн сүүлд 2015 оны 10 дугаар сард Дэлхийн худалдааны байгууллагад тус улсад 2009-2014 оны хооронд хэрэгжүүлсэн татаас, татварын хөнгөлөлтүүдийн талаарх тайланг гаргасан байна. Үүнээс малчдад хамааралтай татаас, хөнгөлөлтүүд нь дараах хөтөлбөр арга хэмжээнүүд юм. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн нөөц, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад зориулсан татаас. Үүнд, нийтийн эзэмшлийн бэлчээр, загасны аж ахуйн нөөц, тэнцвэртэй байдлыг хадгалах зорилгоор Хятадын Сангийн яам, Хөдөө аж ахуйн яамнаас орон нутгийн захиргааны байгууллагуудаар

дамжуулан малчдад татаас өгсөн. Малчдад малын ноос, ноолуурын гарцыг нэмэгдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулахад зориулан татаас өгсөн. Нийт хөдөө аж ахуйн нөөц, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад зориулж дараах хэмжээний хөрөнгийг Засгийн газраас зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт 16: Хөдөө аж ахуйн нөөц, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад зориулсан татаас

/сая юань/

2009	2010	2011	2012	2013	2014
1,764.73	1,893.98	13,728.00	15,428.00	16,375.00	18,315.40

Эх сурвалж: Дэлхийн худалдааны байгууллага

2. Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, сүлжмэл бүтээгдэхүүний худалдааг дэмжих сан: Үүнд тус салбарт чанарын хяналтын баталгаа болон бүтээгдэхүүний гарал угсааг бүртгэх, шинэ техник, технологи нэвтрүүлэхэд зориулсан хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн шууд татаас олгосон. Үүнд Засгийн газраас 2009 онд 100 сая юанийг зарцуулсан гэж тайлагнасан байна.
3. Малчид тариачдын эдийн засгийн нөхөрлөл, хамтын ажиллагаанд зориулсан сан: Харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан малчид, тариачдын холбоо, нөхөрлөлд зориулан татаас, санхүүжилт олгодог. Энэхүү хөтөлбөрт Хятадын Засгийн газраас дараах хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт 17: Малчид тариачдын эдийн засгийн нөхөрлөл, хамтын ажиллагаанд зориулсан татаас

/сая юань/

2009	2010	2011	2012	2013	2014
500.00	600.00	700.00	850.00	1,850.00	2,000.00

Эх сурвалж: Дэлхийн худалдааны байгууллага

Энэ төрлийн байгууллага, холбоод нь малчдын хувьд шинэ мэдээ, мэдээлэл олж авах, шинэ туршлага нэвтрүүлэх боломжийг бүрдүүлдэг бөгөөд Засгийн газар болон томоохон үйлдвэрлэгчид нь мэргэжлийн холбоод, нөхөрлөлүүдтэй хамтран ажиллаж ноолууран түүхий эдийн чанарыг эрс нэмэгдүүлсэн юм.

4. Хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухаан технологийн дэвшлийг нэвтрүүлэх сан: Энэхүү сангийн хөрөнгийг орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан техник, технологийн дэвшлийг хөдөө аж ахуйн салбарт нэвтрүүлэх төсөл, санаачилгыг дэмжин шууд санхүүжүүлэх байдлаар олгодог. Тус хөтөлбөрт зарцуулсан нийт хөрөнгийн мэдээлэл:

Хүснэгт 18: Хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухаан технологийн дэвшлийг нэвтрүүлэх сангаас олгосон татаас

/сая юань/

2009	2010	2011	2012	2013	2014
4,070.00	5,400.00	6,100.00	10,100.00	10,970.60	12,353.90

Эх сурвалж: Дэлхийн худалдааны байгууллага

8. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хятадын эдийн засгийн хурдацтай өсөлтийн нөлөөгөөр дундаж давхаргын эзлэх хувь өсөн үүнтэй холбоотой тансаг хэрэглээний бараа, бүтээгдэхүүн эрэлт, тэр дундаа сайн чанарын ноолууран бүтээгдэхүүний эрэлт эрчимтэй өссөөр байна. Энэхүү боломжийг ашиглахын тулд Хятадын хэрэглэгчдийн хэрэглээг тодорхойлж буй эдийн засаг, нийгэм болон хүн ам зүйн хүчин зүйлсэд гарч буй өөрчлөлт шинэчлэлтийг үйл ажиллагаатайгаа уялдуулж чадвал зах зээлд нэвтрэх боломж нээлттэй байна.

Хятад улсын ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1990-ээд оноос эрчимтэй хөгжин дэлхийн зах зээлд чухал байр суурь эзлэх болсон.

Хятад улс нь ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүх шатанд алсын хараатай хөгжлийн бодлогын хүрээнд малчид болон үйлдвэрлэгчдээ санхүүгийн төрөл бүрийн дэмжлэг, урамшууллын хүрээнд бүх чиглэлээр дэмжиж иржээ.

Хятад улсын ноос, ноолуурын салбараа хөгжүүлж ирсэн туршлага дээр үндэслэн дараах арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой байна. Үүнд:

<u>Бодлогын түвшинд:</u>

- Монгол хонь, ямааны үүлдэр угсааг сайжруулах, энэ чиглэлийн судалгаа, шаардлагатай арга хэмжээг Засгийн газар, орон нутгийн захиргааны байгууллагууд болон үйлдвэрлэгч, малчдын нэгдсэн мэргэжлийн холбоо, нөхөрлөлтэй хамтран хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна. Монгол ноолуурын онцлог давуу талыг дэлхийд сурталчлан сайн чанарын түүхий эдээр сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон хэмээх имижийг бүрдүүлэх, монгол ямааны ноолуурын чанарыг сайжруулах нь тус салбарын бүх шатны үйлдвэрлэл эрхлэгчдэд тустай.
- Дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд төрөөс шаардлагатай дэмжлэг үзүүлэх. Үүнд:
    - Тоног төхөөрөмжийн шинэчлэлийг татаас, татварын хөнгөлөлт үзүүлэх, бага хүүтэй зээлийн эх үүсвэрээр хангах зэргээр дэмжих

- Гадаадын зах зээлд бүтээгдэхүүн гаргахтай холбоотой маркетинг, даатгал, оюуны өмчийн болон гадаад оронд салбар дэлгүүр нээхэд дэмжлэг үзүүлэх, зарим зардалд татаас олгох
- Монгол брэнд хөгжүүлэхтэй холбоотой олон улсын сургалт, семинар, зөвлөхийн үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлэх, дотоодын компаниуд гадаад зах зээлд бүтээгдэхүүн гаргахад урамшуулах, олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцох зэрэг үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Дотоодын үйлдвэрлэгчдийн чадавхыг нэмэгдүүлэх, шаардлагатай сургалт, арга хэмжээг мэргэжлийн холбоодоор дамжуулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төрөл бүрийн шатанд шаардлагатай судалгаа шинжилгээг байнга явуулан тус салбарын хөгжлийг бодлогын зөвлөгөөгөөр дэмжих нь чухал юм.

<u>Компаниудын үйл ажиллагааны түвшинд анхаарах асуудал, зөвлөмж:</u>

- Хятад улсын иргэдийн амьжиргааны түвшин сайжирч, дундаж давхарга нэмэгдэхийн хэрээр ноос, ноолууран бүтээгдэхүүний эрэлт өсөх хандлагатай байгаа тул тус зах зээлд нэвтэрч, байр сууриа эзэлж чадвал манай компаниуд урд хөршийн эдийн засгийн өсөлтөөс хүртэх боломж байна.
- Хятадын зах зээл, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг ойлгох, бизнесийн үйл ажиллагаанд бүх талаар дэмжлэг үзүүлэх Хятад хамтрагчийг өөрийн үйл ажиллагаанд татан оролцуулах нь бизнесийн амжилтад чухал болохыг анхаарах шаардлагатай. Хятадын бизнесийн орчин ихээхэн өөрмөц бөгөөд, төв засгийн газрын болон орон нутгийн удирдлагын байгууллагаас аливаа бизнест оролцох нөлөөлөл байдаг тул стратегийн хамтрагчтай болох нь үүсэх бэрхшээлийг шийдвэрлэх давуу байдлыг авчрах магадлалтай.
- Хятадын Засгийн газраас дотоодын ноос, ноолуур боловсруулах компаниудыг татварын хөнгөлөлт, татаас, хөнгөлөлттэй зээлд

хамруулах зэргээр нэлээд дэмждэг тул өрсөлдөхөд нэлээд бэрхшээл үүсэх боломжтой байна.

- Манай дотоодын компаниуд Хятадын зах зээлд ганц нэгээр гарахаас илүүтэйгээр хамтран ажиллаж, үйл ажиллагааны уялдаагаа нэмэгдүүлэн бизнесийн эрсдэлээ бууруулах замаар нэгдсэн байдлаар нэвтэрвэл илүү боломжтой байх магадлалтай.
- Монголын ноос, ноолуурынхолбоогоор дамжуулан эсхүл холбооны гишүүн байгууллага Хөдөө аж ахуйн биржийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр *(http://pcsp.gov.mn/n/1161)* ажиллавал түүхий эд, мэдээлэл, хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой.

9. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Chen, T. and Xiao, H. (2016), “Study on the Regional Distribution and the Influence Cashmere Production China Factors”, Agricultural Economics and Management, vol.6, pp 74-80

2. Hong Kong Trade Development Council, (2017), “China’s Garment Market”, *http://www.hktdc.com/research*

3. International Monetary Fund, (2017), “Country Report No.17/247: People’s Republic of China*”, http://www.imf.org*

4. International Trade Center official website, *https://www.trademap.org/Index.aspx*

5. Jiang, M., Sun Z., Ding, L., and Xigo, H. (2013), “Study on International Competitiveness and Its Influence Factors of Chinese Cashmere Industry”, Research of Agricultural Moderazation, vol. 1, pp 63-67

6. Jun, Y., Xiao, P., Yu, Q. and You, Z. (2015), “Path Analysis of the Economic Characters of the Inner Mongolia White cashmere Goats”, Journal of Experimental Biology and Agricultural Sciences, vol. 3(3), pp 269-274

7. Liu, C. and Xiao, H. (2017), “Features and Trends of China’s Cashmere Production”, Agricultural Outlook, vol. 4, pp 38-41

8. Nigxia, L. (2016), “The Formation of the Cashmere Industry Competitiveness from Nigxia Lingwu City Comparison with Inner Mongolia Linhe District”, Heilongjiang Animal Scien ce and Veterinary Medicine, vol.04, pp 51-54

9. Shi, J. and Xiao, H. (2014), “Analysis on Comparative Advantage of Production Regions in China”, Agricultural Economics and Management, vol.2, pp 75-95

10. UL, (2017), “China Market Access: National Standards for Textile and Apparel*”, http://ul.com/crs*

11. US-China Economic and Security Review Commission, (2007), “China’s Support Programs for Selected Industries: Textile and Apparel”, *https://www.uscc.gov*

12. World Trade Organization, (2017), “Report of the Committee on Subsidies and Countervailing Measures: New And Full Notification Pursuant to Article HVI: 1 of The Gatt 1994 And Article 25 Of The Agreement on Subsidies and Countervailing Measures: China”, *http://www.wto.org*

13. Yang, X. and Li, Z. (2017), “Thoughts on Current Situation and Development of Cashmere Industry in China”, Wool Textile Journal, vol.45, pp 84-87

14. Yuanyuan, L. (2011), “ The Study of Leap-forward and Sustainable Development in Chinese Cashmere Industry”, Asian Social Science, vol. 7, pp 136-141

15. Zhang, Y. and Xiao, H. (2016), “Analysis on Ranchers’ Choice and Influencing Factors of Vertical Collaboration: A Case Study of Cashmere Industry”, Research of Agricultural Modernization, vol. 37(4), pp 709-715

16. Өвөр Монголын Ордос ресурс ХК (Inner Mongolia Eerduosi Resources JSC), http://www.chinaerdos.com

17. Өвөр Монголын Кинг Дийр кашемир ХХК (Inner Mongolia King Deer Cashmere Co.,Ltd), http://www.kingdeer.com.cn/

18. Тэнг кашемир продуктс ХХК (Teng Cashmere Products Co., Ltd), http://www.yutengcashmere.com/

19. Чифенг Донронг кашемир дэвэлопмент групп ХХК (Chifeng Dongrong cashmere development Group Co., Ltd), http://www.dongronggroup.com